



# УВС АЙМАГТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

2008-2016 он



2008 он

## **АГУУЛГА**

Өмнөх үг

## **Нэг. ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Увс аймгийн өнөөгийн байдал
  - 1.1.1. Байгалийн нөөц
  - 1.1.2. Нийгэм эдийн засгийн нөөц
  - 1.1.3. Түүх соёлын нөөц

## **ХОЁР. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

- 2.1. Аялал жуулчлалын дотоод дүн шинжилгээ
  - 2.1.1. Салбарын дүр төрх
  - 2.1.2. Нөхцөл байдлын шинжилгээ
  - 2.1.3. Аялал жуулчлалын хэрэгцээний статистик дүн шинжилгээ
- 2.2. Аялал жуулчлалын суурь нөөцүүд, тэдгээрийн үнэлгээ
- 2.3. Үйлчилгээний хангамж
  - 2.3.1. Байрлуулах үйлчилгээ
  - 2.3.2. Хоол ундааны үйлчилгээ
  - 2.3.3. аяллын замнал

## **ГУРАВ. ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛГО, СТРАТЕГИ**

- 3.1. Хөгжлийн хөтөлбөрийн эрхэм зорилго, зорилтууд
- 3.2. Аймгийн аялал жуулчлалын стратеги төлөвлөлт
  - 3.2.1 Зорих газрын төлөвлөлт ба бүсчлэл
  - 3.2.2 Бүтээгдэхүүн үйлчилгээний стратеги
  - 3.2.3 Маркетингийн төлөвлөлт

## **ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ 2008-2016 он**

**Хавсралт**  
**Хөтөлбөрийн гол оролцогчид**

## ӨМНӨХ ҮГ

Увс аймаг нь Монгол орны хамгийн том нуурыг агуулдагийн зэрэгцээ, том, бага хэмжээний олон тооны цэнгэг болоод давст нууртайгаараа онцлог. Манай орны мөстлөгийн нийт талбайн 1/4 нь энэ аймагт оршдог. Бас дэлхийн элсэн цөлийн хамгийн хойд зах, Монгол орны говийн бүс нутгийн хамгийн хойд хязгаар ч тус аймагт ирж төгсдөг. Дэлхийд ховордсон цоохор ирвэс, аргаль хонь тэргүүтэй байгалийн олон бүс, бүслүүрийг төлөөлсөн амьтны аймаг цогцлон бүрдэснээрээ өвөрмөц. Энэ мэтчилэн байгалийн бүс, бүслүүр, экосистемийн олон иж бүрдлийг агуулсан **“Дэлхийн өв”**-ийн өлгий нутаг юм.

Увс нуурын ай савын дархан цаазтай газар нь 1997 онд НҮБ-ын олон улсын шим мандлын нөөц газрын сүлжээнд, 2003 онд дэлхийн өвийн сүлжээ, 2004 онд олон улсын ач холбогдол бүхий нүүдлийн шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцид тус тус нэгдэн орсон.

Монгол оронд аялал жуулчлал хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд Увс аймаг нь байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх сонирхол татахуйц бүс буюу Б зэрэглэлд орсон нь аялал жуулчлал хөгжүүлэх боломж, байгалийн нөхцөл нөөц буйг илтгэхийн зэрэгцээ зүй зохистой хөгжлийн бодлого хэрэгжүүлснээр нэг талаас орон нутгийн төсөв, иргэдийн орлогыг нэмэгдүүлж цаашлаад ажилгүйдэл, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлуудыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх нөгөө талаас аялал жуулчлалыг өөрийг нь байгаль хамгаалах арга хэрэгсэл болгон байгальд сөрөг нөлөөлөл багатайтайгаар хөгжүүлж орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах асуудлуудыг шийдвэрлэх боломжтой.

Увс аймгаар аяладаг жуулчдын тоо сүүлийн жилд нэмэгдэж, түүнийгээ дагаад үзүүлэх үйлчилгээний нэр төрөл, цар хүрээ ч бага багаар тэлж байна. Шинэ төрлийн энэ хөгжлийг дагаж аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбогдуулан орон нутгаас гаргах аливаа шийдвэр нь байгаль орчинд сөрөг нөлөө багатай, урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгоход чиглэгдсэн байх, энэ салбарын үйл ажиллагаанд оролцож байгаа талууд тэгш эрхтэй, харилцан ашигтай хамтран ажилладаг болох зорилгыг агуулсан **“Увс аймагт аялал жуулчлал хөгжүүлэх”** хөтөлбөр боловсруулж байна.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар болон Аймгийн Засаг даргын тамгын газар, ИТХ-ын хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөлийн идэвхи санаачлага оролцоотойгоор “Увс аймагт аялал жуулчлал хөгжүүлэх” хөтөлбөрийг боловсруулсан.

Энэхүү хөтөлбөрийг Монгол улсад аялал жуулчлал хөгжүүлэх талаар баримтлах үндсэн чиглэл, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын баруун бүсийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн хөтөлбөр, аялал жуулчлалын хөгжлийн стратегийн төлөвлөгөө, аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тогтвортой хөгжлийн хөтөлбөр хууль эрх зүйн актад үндэслэн боловсруулсан болно.

## НЭГ. ҮНДЭСЛЭЛ

### 1.1 УВС АЙМГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


#### 1.1.1 Байгалийн нөөц

##### Газарзүйн байрлал

Увс аймаг нь Монгол орны баруун хэсэг Их нууруудын хотгорын хойд хэсэгт өргөрөгийн дагуу сунаж тогтсон 69.6 мян.км<sup>2</sup> газар нутагтай. Баруун талаараа 200 км Баян-Өлгий, өмнө талаараа 152 км Ховд аймаг, зүүн талаараа 340 км Завхан аймаг, хойд талаараа 575 км ОХУ-тай тус тус хиллэдэг. Нийслэл Улаанбаатараас 1417 км алслагдсан. Аймгийн төв Улаангом сум д.т.д 939 метр өндөрт оршдог.

/зураг.1/

Зураг: Увс аймгийн газрын зураг



Увс, Хяргас нуур түүний эргэн тойрны говийн бүс, Хархираа, Түргэн, Ханхөхийн өндөр уулс бүхий говь, цөлөөс өндөр уулын мөнх цас мөсөн гол хүртэлх төв Азийн гадагш урсгалгүй ай савын босоо бүслүүрийн бүхий л хэв шинжийг тусгасан ландшафт газарзүйн өвөрмөц тогтоцтой.

Нутгийн 8.2%-ийг уулын ойт хээр, 14.5%-ийг өндөр уулын, 37.7%-ийг хээрийн, 39.6%-ийг говь цөлийн бүс эзэлдэг.

Байгалийн мужлалтаар Увс, Хяргас нуурын хотгорын цөлжүү хээр, хуурай хээрийн дэд муж, Ханхөхийн нурууны дундаж өндөр бэлэрхэг уул бүхий хээр, хуурай хээр, ар хажуугийн ойн дэд муж, Монгол Алтайн зүүн хэсгийн /Хархираа, Түргэн/ цулдам уул, хотгор ян сарьдаг, уулын нуга, уулын хээрийн дэд мужид тус тус багтана. Ийнхүү мөнх цаст өндөр уулсын бүслүүрээс ойт хээр говь цөлийн бүсэд шилжих байгалийн олон бүс бүслүүрийг хамран орших нь аялал жуулчлалын олон төрөл хэлбэрийг нэгэн зэрэг хөгжүүлэх давуу талтай.

Нутгийн баруун хэсэгт Хархираа уул /4037м/, Дэглий Цагаан /3978м/, Түргэн уул /3385м/, Алтан Хөхий уул /3350м/, Цагаан шувуут уул /3496м/, Улаан өндөр /2404м/, Байрам уул /2950м/, зүүн хэсэгт Ханхөхийн нурууны ноён оргил Дуулга /2928м/, Онц уул /2280м/, Хөх өндөр /2436м/, Цагдуулт уул /2329м/ зэрэг өндөр уулстай нь уулын аялал хөгжих гол нөхцөл бүрдсэн давуу талтай.

Хамгийн нам цэг нь д.т.д 758.9 м Увс нуурын түвшин, хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс дээш 4037 метрт өргөгдсөн Хархираа ноён оргил юм. Увс нуурын хотгорын зүүн талд Ханхөхийн нурууны араар үргэлжлэн Бөөрөг дэлийн элс /дэлхийн бөмбөрцгийн хамгийн хойшоо түрж орсон манхан элс хойд өргөргийн 50°18'1/ баруунаас зүүн тийш 180км үргэлжилдэг.

Нийт 6 958 539 га газар нутагтайгаас газар тариалангийн талбай 45 332 га, ой мод 110 212 га, бусад талбай 6 802 995 га-г тус тус эзлэнэ. Нийт нутаг дэвсгэрийн 68.5%-нь малын бэлчээр, 1.5 %-ийг ой хөвч эзлэх бөгөөд шинэс, улиас, бургас, нарсан ой голлон ургадаг. Увс аймгийн нутгийн 1278464.4 га газар буюу 18.3% нь улсын тусгай хамгаалалтанд 374178га газар аймаг, сумын тусгай хамгаалалтанд орсон байдаг.

**Зураг 2: Нутаг дэвсгэрийн тусгай хамгаалалтанд хамрагдсан байдал**



Аймгийн нутаг дэвсгэрт өвөрмөц сонин тогтоцтой, сонирхол татах хэлбэр дүрстэй геологийн биетүүд, археологийн олдвор бүхий газар нутаг олон байна. Хархираа, Түргэний уулсаар венд, кембри, ордовик, силурийн цахиурлаг шаварлаг занар, алевролит, девоний граносиенит, Ханхөхийн уулсаар кембрийн тоналит, гранодиорит, Увс, Хяргас нуурын хотгороор дөрөвдөгчийн тунамал хурдас, гуравдагчийн улаан алаг хурдсууд тархана. Тус аймаг нь нүүрс, алт, давс зэрэг эрдэс баялгийн нөөц ихтэй. Нүүрст хотгор, Хүдэн, Хар тарвагатай чулуун нүүрсний ордууд нь нийт 167.26 сая.тн нөөцтэй. Жилд 150-200 мянган тонн нүүрс олборлох боломжтой. Давст сумын Шүдэн уулын давсны ордын нөөц нь 6 сая тонн . Өлгий сумын Баруун улааны усан ба утаат болор зэрэг үнэт чулууний орд илэрцүүдтэй.

**Уур амьсгал:** Их нууруудын хотгор, Алтайн салбар уулсын бүсэд орших тул эрс тэс эх газрын уур амьсгалтай. Увс нуурын хотгор нь эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн уулс хоорондын хотгор төдийгүй төв Азийн антициклоны төв юм. Өвлийн улиралд агаарын даралт 1-р сард 1054 гПа хүрч Улаангомьн цаг уурын станцад тэмдэглэснээр агаарын температур 1-р сард  $-50^{\circ}\text{C}$  хүрдэг нь монгол оронд тэмдэглэгдсэн хамгийн бага утга тул Увс нуурын хотгорыг Монгол орны хамгийн хүйтэн газар гэж үздэг.

Агаарын температурын сарын дундажыг үзэхэд Увс нуурын хотгорт хамгийн хүйтэн газар нь Баруунтуруун сум жилийн температур  $-4.9^{\circ}\text{C}$ . Хаврын улирлын агаарын дундаж температур  $-5^{\circ}\text{C}$ , дулаарсанаас хойш  $+10^{\circ}\text{C}$  заагийг хүрдэг, зуны улирал нь 5-р сарын 16-аас 9-р сарын 07-ыг хүртэл 111-114 хоног үргэлжлэх бөгөөд Улаангомь сум орчимд 5-р сарын 10-аас 9-р сарын 15 хүртэл 128 хоног үргэлжилнэ. Хоногийн дундаж агаарын температур 6-р сарын эхнээс 8-р сарын 15-ыг хүртэл нийтдээ 70 гаруй хоног  $+15^{\circ}\text{C}$  дулаан байна.

Нутгийн хэмжээгээр нийт үүлшлээр 6-р сард 6.8-7.3 өдөр, 7-р сард хамгийн олон 8.1-9.5 өдөр, 8-р сард 5.3-6 өдөр бүрхэг байна. Агаарын температурын жилийн дундаж хэм өмнөх онтой харьцуулахад  $-2^{\circ}\text{C}$ -ээр буурч 2006 оны байдлаар  $-1.4^{\circ}\text{C}$  хэм байна /График.1/. Судлаач эрдэмтэн Г. Намхайжанцан “Монгол орны амралт рашаан сувилал, аялал жуулчлалд зориулсан хүний нөөцийн биеийн био уур амьсгал” –ын 3 мужийг тогтоосон бөгөөд Увс аймаг нь I, II мужид багтсан байна<sup>1</sup>.

Хүснэгт 1

Муж	Цаг агаар хүний биед /хоногоор/			Цаг агаарын хувьслын индекс
	Тохиромжтой	Харьцангуй	Тохиромжгүй	
I	300-325	14-80	5-15	25 тогтвортой-алгуур
II	250-300	35-115	15-30	25-30 харьцангуй

I мужид Увс аймгийн Цагаан шувуут, Хархираа, Түргэн, Ханхөхийн уулс хамрагдана. Увс аймгийн хувьд 7, 8-р сар нь аялал жуулчлал явуулахад хамгийн тохиромжтой. Харьцангуй чийгшил 8-р сард 57-67% байна. Салхитай өдрийн тоо багасаж хур тунадастай өдрийн тоо өмнөх онтой харьцуулбал 4 өдрөөр өссөн байна /График.2/. Их нууруудын хотгорт жилд дунджаар 100-150мм, тал хээрийн бүсэд 200-250мм, өндөр уулын бүсэд 250-300мм тунадас унана. Жилийн дундаж

<sup>1</sup> Г. Намхайжанцан “Эрс эх газрын хэрэглээний уур амьсгал” УБ хот 2001 он 28-р тал

тунадас нь сумдаар авч үзвэл хамгийн их нь Малчин сум 263.8мм, хамгийн бага нь Сагил сум нь 21.8мм тунадас унадаг.

Хамгийн их тунадастай үе нь 7, 8-р сар бол хамгийн бага нь 1, 2-р сар юм. Өвлийн улиралд Малчин, Баруунтуруун суманд дотоодын аялагчдад тулгуурласан цана, чарга гэх мэт спортын хэрэгслээр аялах аялал, уралдаан тэмцээн зохион байгуулах боломжтой.

**Ус зүй:**

Ус зүйн сүлжээний хувьд бараг бүхэлдээ төв азийн гадагш урсгалгүй ай савд багтана. Аймгийн усны нөөц нь 1.212 км<sup>3</sup>/жил, Өрнөд бүсийн усны нөөцийн 12.8 хувийг эзлэнэ<sup>2</sup>.

Монгол Улсын Байгаль орчны сайдын 2007 оны 09 сарын 10 –ны 265 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Увс аймгийн Засаг даргын 2007 оны 10 сарын 08-ны 397 тоот захирамжаар байгуулагдсан аймгийн ажлын хэсэг, улсын усны тооллогын баруун бүсийн багтай хамтран Увс аймгийн 19 сумын нутагт нийт 177 гол горхи, 113 нуур, цөөрөм, 462 булаг, 28 рашаан, 434 худаг, 7 услалтын систем, 7 усан сан, хөв цөөрөм, 10 цооног, 1 цэвэрлэх байгууламж, 1 УЦС, 1 мөсөн гол, 3 далан тоологдсон байна.

**Тэсийн гол:** Булнайн нуруунаас эх авч Увс нуурт цутгадаг. Нийт урт 568км бөгөөд 33358 хавтгай дөрвөлжин км талбайгаас усжина, усны зонхилох гүн 0.3-2.5м, урсгалын хурд 0.7-1.5м/сек орчим юм<sup>2</sup>.

**Нарийн гол:** Баян нуур Бөөрөг дэлийн булгаас эх авч 70 орчим км урсаж Увс нуурт цутгана.

**Хархираа гол:** Мөнх цаст Хархираа уулнаас эх авч увс нуурт цутгадаг. Уулын ширүүн урсгалтай, тунгалаг хүйтэн устай, голын урт 115 км, сав газрын талбай 704 ам.дөрвөлжин км, хэвгий 13.2 хувь болно. Хөндийд нь тоорой, хар мод ургадаг.

**Боршоо гол:** Баруун тагнын нуруунаас эх авч Увс нуурт цутгадаг цэнгэг устай гол. Голын урт нь 88км, сав газрын талбай 1271 ам.дөр.км, хэвгий 13.2% байна. Монгол хадран, шар загас элбэгтэй.

**Торхилог гол:** Тува улсын нутаг Тагнын нуруунаас эх авч 60 орчим км урсаж Увс нуурт цутгадаг. 1623 ам.км талбайтай, хэвгий 19.5 хувь. Увс нуурт цутгах хэсэгт Ногоон дарь эхийн тахилгат овоотой.

**Рашаан ус:** Сүүлийн жилүүдэд монгол оронд дотоодын аялал жуулчлалд нилээд дээгүүр байр суурь эзэлж байгаа аялал жуулчлалын нэг төрөл болох эмчилгээ сувиллын аялал тус аймагт хөгжиж байна. Хяргас нуурын Хар тэрмисийн сувилал, Улаангом чандмань уулын рашаан, Зүүнговийн Уртбулаг, Түргэний Бургастай, Дэлгэрмөрөн, Хавцал, Наранбулагийн Халиунбулаг, Өлгийн Сондуульт, Хяргасын Модот, Хуст, Хүнх, Өмнөговийн Ногоон цэгээн зэрэг газруудад төрөл бүрийн өвчнийг анагаах үйлчилгээтэй эмчилгээний рашаантай. Зүүнговь сумын Уртбулагийн рашаан жилд дунджаар 120 орчим хүн бөөр, ходоод, цөс үе мөчний өвчнийг анагаадаг уг рашаан сувилалд хамрагддаг. Дуу чимээгээр элснээс бургилан гардаг өвөрмөц сонин рашаан. Хяргас нуурын дэргэдэх Хар тэрмисийн сувилал Улаангомоос 140 км зайтай. Дотоод болон гадаадын жуулчид усанд сэлэх, наранд шарах элсэн хаялагатай төдийгүй сувилалд амрах, загасчлах боломжтой.

**Хөрс:** Газарзүйн мужлалтаар Хархираа, Түргэний уулс нь өндрийн бүсшилийн Алтайн хэв шинжид, Хан Хөхийн уулс нь хангайн өмнөдийн хэв шинж, Увс, Хяргас нуурын хотгор нь холимог бүсшилийн их нууруудын хотгорын дэд мужид хамрагдана. Аймгийн нутгийн нам хотгор, говь хээр газраар цөлөрхөг хээрийн бор, цайвар хүрэн, хүрэн, уулархаг газраар уулын хүрэн, уулын хар шороон, уулын

нугын, уулын нугат хээрийн, нуур голын эрэг орчмын газраар хужир мараалаг хэв шинжийн хөрсүүдтэй.

Цайвар хүрэн, говийн бор хөрс хамгийн их тархсан. Нутгийн ихэнхи хэсгээр хүрэн хөрстэй бөгөөд хар шороон хөрс тун бага хувийг эзлэнэ. Увс нуурын хотгорт кайнозойн хурдас өргөн тархсан төдийгүй Улаангом орчимд 500 метр хүрдэг. Тэс нарийн голын сав газар, Бөөрөг дэлийн элсэнд пролювийн гаралтай дөрөвдөгч галавын хурдас зонхилно. Хархираа, Түргэн, Цагаан шувуутын уулсаар тундрын болон нугын, уулын хээрийн хөрстэй. Түүний салбар уулс нь нугын ба хээрийн хөрстэй. Хан Хөхийн нуруу, Тогтохын шилээр уулын хүрэн, Зүүнговь, Тэс, Завхан сумын нутгаар голдуу элсэн хөрстэй.

**Ургамал:** Аймгийн нутагт говь-хээрийн бүс зонхилсон өвс ургамал нөмрөгийн хувьд тачирдуухан боловч төрөл зүйл олон, жимс жимсгэний ургамалтай.

Хархираа, Түргэний уулын тундрын бүстэй, дундаж өндөр уулсаар алаг өвс-жигиг бутлаг-үетэнт хээр зонхилно. Хан Хөхий, Түргэний ар хажуугаар улалж, алаг өвст шинэсэн ойтой. Ой модны эзлэх талбай 185,6 мян.га, нийт нөөц нь 19152,1 мян.м<sup>3</sup> бөгөөд ойн нөөцөөр баруун бүсэд Завхан аймгийн дараа орно. Увс нуур орчмын газраар үетэн-таарт, шарилжит, Хяргас нуур орчмын газраар баглуур-сайрын хялганат, цөлжүү хээртэй. Бөөрөг дэлийн элсээр элссэг алаг өвст, шарилжит, үетэнт, харганат хээртэй. Нутгийн 8,2%-ийг хээр, 14,5%-ийг өндөр уулын, 37,7%-ийг хээрийн, 39%-ийг говь цөлийн бүс эзэлнэ. Хар мод, хус, хуш, нарс, улиас, бургас, улаан харгана, алтан харгана нутгийн ихэнхи хэсгээр тархсан. Зүүнговь, Сагил, Түргэн сумын нутгаар мөнх ногоон гацуур модтой. Увс нуурын эрэг орчим, Тэсийн голын адаг орчмоор улиасан төгөл, бургасан шугуй, тэмээн харгана бүхий алаг өвст, үент, нугын бүлгэмдэл зонхилно. Алтангагнуур, вансэмбэрүү, алтан хундага, нохойн хошуу, тарваган шийр, халгай, таван салаа, хунчир зэрэг эмийн ургамалтай. Чацаргана, үхрийн нүд, гүзээлзгэнэ, тошлой, мойл, анис, зэдгэнэ зэрэг жимс жимсгэнэтэй.

**Амьтны аймаг:** Увс аймагт 64 зүйлийн хөхтөн, 270 зүйлийн шувуу, 7зүйлийн загас, 411 зүйлийн ургамалтай. Хан Хөхий, Хархираа, Түргэний уулсаар буга, гахай, аргаль, янгир, ирвэс, шилүүс, хадны суусар, нохой зээх, хээр тал зарим голын хөндий уулархаг нутгаар чоно, үнэг, дорго, тарвага зэрэг ан амьтан амьдардаг. Нууруудад хун, нугас, хотон зэрэг усны шувууд, уул талаар хойлог, тоодог, тас, бүргэд, ёл, Ховд, Бөхмөрний голд алтан гургалдай зэрэг төрөл бүрийн жигүүртэн шувуудтай. Тэс, Нарийн голын сав нь хүйтэн цуст амьтад амьдардаггүй бүсэд хамаарна. Бөөрөг дэлийн элсний районд хээрийн бүлгэмдэл тархсан. Хонин гүрвэл, говийн гүрвэл, могой гүрвэл, бамбай хоншоорт могой зэрэг мөлхөгчидтэй. Ан агнуурын амьтдаас хярс, мануул, өмхий хүрэн, солонго элбэг бол агнуурын шувуудаас ногтруу, дагуурын ятуу элбэг тархсан.



## 1.1.2 Нийгэм эдийн засгийн нөөц

### Засаг захиргаа

Дөрвөд далай ханы аймаг, Зоригт ханы аймгийг нэгтгэж 1925 онд Чандмань уулын аймгийг байгуулж, улмаар 1931 оны 2 сарын 6-нд Увс аймгийн хилийн заагийг тогтоосноор Увс аймгийн засаг захиргааны хуваарь үүссэн.

Монгол Улсын Их Хурлын 1994 оны 33-р тогтоолоор Увс аймгийн төв Улаангом сумыг байгуулсан.

Увс аймаг нь засаг захиргааны нэгжийн хувьд 19 сум 92 багт хуваагддаг. Нутаг дэвсгэрийн хэмжээг баруун бүсийн аймгуудтай харьцуулбал /график.3/ 16.8% буюу Говь-Алтай, Завхан, Ховд аймгийн дараа 4 дүгээрт ордог.

Аймгийн төвөөс хамгийн ойрхон сум Түргэн 28 км, хамгийн алслагдсан нь Зүүнхангай сум 350 км зайтай.

### Хүн ам

Тус аймаг нийт 2006 оны байдлаар 80.5 мянган хүн амтай. 20.1 мянган өрхтэй, нийт хүн амын 28.6 хувь нь хот, 71.4 хувь нь хөдөөгийн хүн ам. Хүн амын тоо өмнөх оныхоос 0.1 мянгаар буурсан байна /График.4/. Хүн амын нягтшил 1 кв.км-т ногдох хүн 1.16 харьцуулбал /График.5/ Баян-Өлгий аймгийн дараа буюу 2 дугаарт ордог.

Хүн амын тоог баруун бүсийн аймгуудтай харьцуулбал 2005 онд Баян-Өлгий Ховд аймгийн дараа 3 дугаарт, 2006 онд Баян-Өлгий, Ховд, Завхан аймгийн дараа 4 дүгээрт орж байна. Хүн амын өсөлтийн жилийн дундаж 2005 онд 1.5%, 2006 онд 0.12%-ийн бууралттай байсан байна.

Үүнийг төв рүү шилжих хүн хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбон тайлбарлаж болох юм. Нийт хүн амын 40.2% нь дөрвөд, 35.2 % нь баяд, 15.3 % нь халх, 9.3 % нь хотон болон бусад ястан амьдардаг. Тус аймагт хамгийн олон тоотой ястан нь дөрвөдүүд. Дөрвөдүүд Бөхмөрөн, Давст, Өлгий, Өмнөговь, Сагил, Түргэн, Ховд сумдын нийт нутгаар, Улаангом, Наранбулаг сумын нутгийн зүүн хагаст оршин сууж байна.

Хөдөлмөр эрхлэж буй 32.5 мянган хүн үүнээс төрийн албан хаагч 3.8 мянга. Ажилгүйдлийн түвшингээр Баян-Өлгий аймгийн дараа 2 дугаарт ордог /График.6/. 2006 оны байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүд нийт 1894. Үүнээс 1026 эмэгтэй, дээд боловсролтой 210, тусгай дунд боловсролтой 120, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн 274, мэргэжилгүй 1290 хүн байна.

**Эдийн засаг:** Орон нутгийн төсвийн орлого 2006 онд өмнөх оноос 297.6 сая төгрөгөөр өсөж 1852.7 сая төгрөг. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг 776.9 сая төгрөг байна. Төсвийн зарлага 2006 онд 1860.2 сая төгрөг байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтаар улсад 11-р байранд харин баруун бүсийн аймгуудын дотор тэргүүлдэг.

Аймгийн үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг өмнөх онтой харьцуулбал 627.3 сая төгрөгөөр өссөн ба 3250.5 сая төгрөг байна /График.14/

2006 оны байдлаар аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 49.8 тэрбум төгрөг бөгөөд үүнээс 68.4 хувь нь хөдөө аж ахуй, 31.2 хувь нь үйлчилгээ, 0.4 хувь нь аж үйлдвэр барилгын салбар эзэлж байна. /График.14/

Хүн амын амьжиргааны доод түвшин баруун бүсэд 2004 онд 20200 төг, 2005 онд 23200 төг, 2006 онд 37000 төг, 2007 онд 54700 төгрөг буюу Улаанбаатар хотоос 5400 төгрөгөөр бага байна. Импортоор ОХУ, Хятад улсаас хүнсний болон

ахуйн хэрэгцээний зүйл авдаг. Чацаргана, жамц давс, үхрийн мах, адууны мах, загас, малын гаралтай түүхий эд, монгол гэр экспортод гаргадаг.

Аймгийн эдийн засгийн үндэс болсон хүн амын эрхэлж ирсэн гол аж ахуй болох бэлчээрийн мал аж ахуй. Ноос ноолуур, махны чиглэлтэй хонь, ямаа, үхэр, адууны аж ахуй зонхилдог. Сүүлийн жилүүдэд малын тоо толгой тогтмол өсөж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулбал 379.6 мянгаар өссөн байна /График.7,8/

2006 оны байдлаар нийт 2400.9 мянган малтай үүнээс 48.5% буюу 1164.8 мянган толгой хонь, 42.4% буюу 1019.7 мянган толгой ямаа, 5% буюу 120.0 мянган толгой үхэр, 3.4% буюу 80.2 мянган адуу, 0.7% буюу 16.1 мянган толгой тэмээ эзэлж байна.

2006 оны эцсийн байдлаар нийт малын тоогоор баруун бүсэд Завхан аймгийн дараа буюу 2 дугаарт, /График.9/ улсад Хөвсгөл, Өвөрхангай, Завхан, Архангай аймгуудын дараа буюу 5 дугаарт орж байна.

Аймгийн малын тоог сумдаар авч үзвэл хамгийн олон малтай сум нь Улаангом сум 190 782 толгой буюу нийт малын 7.1 хувь, хонины тоогоор Тэс сум 163 357 буюу нийт хонины 12.8 хувь ноогдож байна. Завхан сумын нутагт тэмээнд тохиромжтой цөлийн бор саарал хөрстэй баглуурт бэлчээр зонхилдог. Тэмээн аяллыг Зүүнговь сум Баяннуураас Нарийний эх чиглэлд зохион байгуулах боломжтой төдийгүй бусад сумдаар хосолсон аялал ч тохиромжтой.

2006 оны байдлаар 1561.5 мян.га-д үр тариа тариалдаг. 126.3 га-д хүнсний ногоо, 1832.7 төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалдаг. Газар нутгийн ихэнхи хувийг бэлчээрийн талбай эзэлдэг ч Галданбошогт хааны үеэс газар тариалан эрхэлж ирсэн түүхэн уламжлалтай.

**Дэд бүтэц:** Тус аймаг нь дэд бүтцийн салбар сул хөгжсөн. Зам харилцааны сүлжээний сул тал нь замын ихэнхи хэсгийг шороон зам эзэлдэг. Улаангом сумын дотор Хандгайтын чиглэлд 120 км хатуу хучилттай, 973 км гол чиглэлийн сайжруулсан замтай. Боршоогийн боомт-Улаангом-Ховд-Яринтайн чиглэлд нийт 680.0км сайжруулсан хөрсөн зам, 370.0км ердийн хөрсөн замтай. Засгийн газраас “Мянганы зам” төсөл хэрэгжүүлэн баруун чиглэлд Улаанбаатар-Лүн-Дашинчилэн-Өгийн доод гүүр-Батцэнгэл-Хануйн гүүр-Тариат-Цахир-Загастай зүүн эхний даваа-Идэр-Яруу-Эрдэнхайрхан-Завхан-Тээлийн бэлчир-Дөргөн-Мянгад-Өлгий-Цагааннуур-Улаанбайшинтын чиглэлд төлөвлөгдсөн.

Аймгийн агаарын тээврийн газар МИАТ, Аэро Монголиа, Ezniss авиа компаниуд нислэг хийх болсноор жуулчдын цагийн зохицуулалт, аяллын хугацааг төлөвлөх нэгэн таатай орчныг бүрдүүлж байна. Агаарын, авто, ердын хөсгөөр 2,1мя тн ачаа тээвэрлэж байна. Автомашин тоо өмнөх оноос 192-р буурсан бөгөөд 2006 оны байдлаар 2563 авто машин тоологдсоноос суудлын 1745, ачааны 675, автобус 62, цистерн 39, тусгай зориулалтын 42 автомашин байна.

Нийт үйлдвэрлэлтийн 29,5%-ийг эрчим хүч, 23%-ийг алт олборлолт, 16,7%-ийг усан хангамж, 14,6%-ийг хүнсний үйлдвэрлэл, 9,8%-ийг нүүрс олборлолт, 0,9% нь модон бүтээгдэхүүн үйлдвэрлэлт эзэлдэг.

Эрчим хүчний дэд бүтцийн хувьд төвийн бүсийг бодвол сул хөгжилтэй. Харин Баруун бүсийн хувьд Завхан, Говь-Алтай аймгаас илүү нөхцөл бүрдсэн. Улаангом хотыг 1996 онд ОХУ-ын эрчим хүчний системтэй холбожээ. Цөөхөн төв суурин газар төвлөрсөн эрчим хүчний системд холбогдож, бусад нь дизель цахилгаан станцаар эрчим хүчээ хангаж байна. Оросын Холбооны Улсаас эрчим хүч импортоор авч баруун бүсийн эрчим хүчний систем /ББЭХС/-Д Өмнөговь, Өлгий, Түргэн, Тариалан, Сагил, Наранбулаг, Ховд, Завхан, Давст сумдын төв холбогдсон. Төвийн эрчим хүчэнд холбогдоогүй сумдаас

Баруунтуруун суманд 1,95 мян.кВт нийлбэр чадалтай дизель станц ажилладаг нь хамгийн том болох бөгөөд цаашид 300кВт хүчин чадалтай жижиг УЦС Өндөрхангай суманд 200кВт чадалтай жижиг УЦС барьсан нь тус сумыг дулааны улиралд цахилгаан эрчим хүчээр хангадаг. Цаашид сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах, түлш хэмнэлттэй зарцуулах боломжтой дизель станц ашиглах талаар анхаарах хэрэгтэй. Хөдөө малчин өрхүүд нарны эх үүсвэрээр цахилгаан эрчим хүч хэрэглэж байна. 2003 онд Монгол Улсын Засгийн Газраас "Буман нарны гэрэл" төслийн хүрээнд 450 гаруй нарны эх үүсвэрийг тус аймгийн малчдад олгожээ.

Харилцаа холбоо: Улаангомд 2000 номерийн тоон технологитой АТС-тай. 2001 онд аймгийн бүх багууд радио богино долгионы станцаар холбогдож 2002 онд Улаангомд анхны кабелийн телевиз ашиглалтанд орсон. 2003 онд шилэн кабелийн сүлжээнд холбогдсон. 2003 оны эцсийн байдлаар бичиг захидал боодол 11,8 мян ширхэг байсан нь өмнөх оноос 10,3 мян ширхэгээр буурсан байна. Тогтмол хэвлэл 447,8 мянга болж өмнөх оноос 171,5 мянгаар өссөн. Цахилгаан мэдээ 12.8 мян ширхэг бөгөөд өмнөх оноос 1.6-р буурсан ба телефон яриа 9883.9 мянган минут болж өмнөх оноос 2236.5 мянган минутаар өссөн байна.

Боловсрол: 2003-2004 оны хичээлийн жилд 30 ерөнхий боловсролын сургуульд 19,6 мянган хүүхэд суралцаж 765 багш ажиллаж байна. Суралцагчдын тоо өнгөрсөн жилээс 0,7 мянгаар өсөж суралцагчдын 51,6 хувь нь эмэгтэй, 49,4 хувь нь эрэгтэй байна. Хөдөлмөрийн дээд сурууль 1998 онд байгуулагдсан бөгөөд өдөр оройн ангид нийт 174 оюутан суралцагсад, 10 багш ажиллаж байна. Улаангом коллежид 304 оюутан, 953 сурагч мэргэжлийн анхан шатны ангид, 75 багш ажиллаж байна.

Соёлын салбарын хүрээнд аймгийн хэмжээнд 19 соёлын төв, 385 суудалтай 20 номын сан, 13 кино цэг ажиллаж байна. Соёлын төв үзвэрээсээ 5,4 сая төгрөгийн орлоготой, ОНС музейн 13,6 мянган үзмэртэй болж, үзэгчидийн тоо өмнөх оноос 200 хүнээр өсөж 2006 оны байдлаар 2700 хүнд үйлчилсэн байна /График.13/.

### 1.1.3. Түүх соёлын нөөц

Аймгийн нутаг дэвсгэрт эртний түүх соёл, дурсгалт зүйл болох хүн чулуу 104, буган хөшөө 21, хадны сүг зураг 90 гаруй цэгт 40.000 гаруй, бичиг тэмдэгт хөшөө 20, гэрэлт хөшөө 1, хадны бичээс 10, түүнчлэн олон мянган хиргисүүр, цөөнгүй тооны эртний сүм хийдийн үлдэгдэл, туурь бүртгэгдсэн. Чандмань уулын археологийн олдвор нь эртний түүх соёлын нандин өвд тооцогддог.

ОНС музей нийт 5228 үзмэртэйгээс хосгүй үнэт 10 дурсгал бий. Дөрвөд далай ханы эмээлийн мод, сийлбэртэй ган хэт бэл, Даваач хааны гавал аага, Далай хааны хутга, хүрэл зэвсгийн үеийн чулуун хэв, Амарсанаа баатрын хөө хуяг гэх мэт хосгүй үнэт ховор дурсгалтай. Одоогоос 20-15 сая жилийн өмнө амьдарч байсан хярсны ясны үлдэгдэл, чулуун болон хүрлийн үеийн дурсгалууд, Долоодойн уйгар, руни бичигт хөшөө, дөрвөд, баяд, халх, хотон зэрэг олон ястны амьдралын ялгаатай хэв маяг, зан заншил, уламжлал, хувцаслалт, дуу бүжиг, хурим найр, эдлэл тэргүүтэн, Галданбошигтоос оросын цагаан хаанд бичсэн бичиг зэрэг сонирхолтой үзмэрүүдтэй.

Аймгийн түүх соёлын дурсгалыг археологийн ангиллаар нь авч үзвэл: Хүн чулуу: 104 гаруй байгаагаас 6 нь түүх соёлын дурсгалын хувьд ихээхэн ач холбогдолтой төдийгүй сайн судлагдсан.

Хадны зураг: Аймгийн хэмжээнд нийт 90 цэгт 40.000 гаруй хадны сүг зураг тэмдэглэгдсэнээс түүхийн хувьд илүү ач холбогдол бүхий 13 хадны зураг бий. Эдгээрийн 6 нь Сагил сумын нутаг дэвсгэрт, 2 нь Давст сумын нутаг дэвсгэрт байрладаг. Он цагийн хувьд Хүрэл зэвсгийн үед хамаарагдах 5, чулуун зэвсгийн үед хамаарагдах 4, төмөр зэвсгийн үеийн 3, дундад зууны үеийн 1 хадны зураг байна.

Төгсбуянтын хүрээний туурь: Дөрвөд далай ханы гол хүрээ. Энэхүү туурь нь Түргэн сумын нутагт Түргэн, Буурлын голуудын бэлчирт байрладаг. 1758 онд суурийг нь тавьсан гол хийдийг Жигнийлин гэдэг байжээ. Төгсбуянтын хүрээ нь Чогчин, Жүд, Мамба, Чойр, Дүйнхар гэсэн таван том дацан, 22 сүм дуган, 800 гаруй ламтай байжээ. Дорно дахины таван ухааны ном судлан сургалт явуулан хурал ном хурдаг байсан. Хамгийн том цогчин дуган 120 жангийн хэмжээтэй байжээ. Тус хүрээнд 6 том тогоо байсны хамгийн том Баянцагаан гэгч тогоо нь нэг удаа цай чанахад 5-6 шар цайгаар идээ хийдэг байжээ. Төгсбуянтын хүрээ нь 13 жастай байсан ба 1925 оны байдлаар жасын мал 97965 толгой буюу Далай ханы хошууны нийт малын 37.2 хувийг эзлэж байжээ. 1930 онд Төгсбуянтын хүрээний лам нарын бослого гарч, 1937 онд ихэнхи лам нарыг нь баривчлан 1938 онд уг хийдийг тарааж, Дүйнхэрваан уулын оройгоос их буугаар хийдийг буудаж нураасан гэж нутгийн хөгшчүүл хуучлан ярьдаг.

1. Хүн чулуу - 104
2. Бичиг тэмдэгт хөшөө - 20
3. Гэрэлт хөшөө -1 бий. Энэ нь Хяргас сумын нутагт байрлах Да лам Цэрэнчимэдийн дурсгалд зориулж 1916 оны 5-р сарын 20-нд босгожээ.

Хадны бичээс - Нийт 10 гаруй бичээс байдгаас 4 бичээс нь судлагдаж, бүртгэгдсэн.

Төмөр цоргын Руни бичиг анх тэмдэглэгдсэн газраа байгаа эсэх нь тодорхойгүй. Байгалийн элэгдэлд орж хад нь нурснаас хагарч алга болсон.

Сүүлийн үед эдгээр түүх соёлын дурсгалууд байгалийн болон гадны нөлөөллөөс эвдэрч гэмтэх, хуучин хэв байдлаа алдах явдал ихэд ажиглагдаж байна. Хяргас сумын Дэжээлингийн хийдийн 2 том тогооны нэг зэс тогоо нь 1996 онд Хятад улс руу ачигдаж байгаад саатуулагдсан боловч дараа нь алга болсон.

Иргэдийн дунд түүх соёлын дурсгалыг хамгаалах талаар мэдээлэл сурталчилгааны сургалт зохион байгуулах, хөшөө дурсгалыг тогтоол шийдвэрээр хамгаалах төдийгүй урамшууллын тогтолцоо бий болгох, иргэдэд хариуцуулан түүхэн үнэ цэнэийг нь тодорхой баримт судалгаанд түшиглэн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад соёлын өвийн талаар судлах сургалт зохион байгуулах зэргээр түүх соёлын дурсгалыг хадгалж, хамгаалах шаардлагатай.

### Увс аймгийн түүх соёлын дурсгалууд

Хүснэг 2

№	Түүх соёлын дурсгалын нэрс	Байршил алслагдсан зай /км-ээр/	Хамрагдах үе	Тайлбар
1	Борнурганы Хүүхдийн овооны хос хүн хөшөө	Давст сум 140 км	Түрэгийн үе	ЗГ-ын 1998 оны 235-р тогтоолоор улс, аймгийн хамгаалалтанд орсон. Нэг хөшөө нь хугарч унасан, нөгөө хөшөө нь элэгдэлд орж цуурсан.
2	Жаажаагийн хөтлийн хүн чулуу	Наранбулаг сум Зуслан 140 км	Түрэгийн үе	Нэг хөшөө нь хугарч унасан. Нөгөө хөшөө нь хазайж унах аюултай байгаа.
3	Нийчийн амны хүн чулуу	Хяргас сум 168 км	Түрэгийн үе	Толгойн хэсгээрээ 45хэмийн налуутайгаар хагарсан.
4	Овгор хиргисүүрийн хүн чулуу	Хяргас сум 168 км	Түрэгийн үе	Элэгдэлд орсон
5	Халхайтын дэнжийн хүн чулууунууд	Тариалан сум 41 км	Түрэгийн үе	1 хөшөөг нь гадны үйлчлэлээр хугарсан.
6	Хөтөл нуурын бор толгойн хүн чулуу	Малчин сум 122 км	Түрэгийн үе	Улсын хамгаалалтанд орсон.
7	Бургастайн хөндийн ганц харгайтын бичигт хадны зураг	Сагил сум 83 км	Хүрэл зэвсгийн үе	Мал, амьтны үржлийн үеийг билэгдэж дүрсэлсэн.
8	Зураагийн хадны зосон зураг	Зүүнхангай сум 351 км	Чулуун зэвсгийн үе	Наран тал руу харсан тул нар салхи, ус бороонд идэгдэж дүрс тэмдэг нь илт бүдгэрсэн.
9	Можоогийн хадны зураг	Сагил сум 111 км	Дунд чулуун зэвсгийн үе	Палеолитийн үеийн ийм дурсгал дотроос Монгол оронд төдийгүй дэлхийд гайхагдах онцлог

				дурсгал хэмээн эрдэмтэд үнэлдэг.
10	Их сарын хадны зураг	Сагил сум 94 км	Дундад зуун	Зурган байгаа дүрслэл нь 13-р зууны үеийн монголчуудын хувцас хэрэглэлтэй төстэй. Нутгийн хүмүүс Чингисийн хадны зураг гэдэг.
11	Зүүн турагийн тэрэм хадны зураг	Давст сум 129 км	Төмөр зэвсгийн үе	Хад чулуу нь байгалийн элэгдэлд орж нурж эхэлсэн.
12	Саравхын хадны зураг	Наранбулаг сум 116 км	Хүрэл зэвсгийн үе	Аргаль, янгир их хэмжээгээр сүрэглэсэн байдлаар дүрсэлсэн.
13	Тэхтийн давааны хадны зураг	Давст сум 160 км	Хүрэл зэвсгийн үе	Мөнгөт цахирын аманд бий
14	Үнхэлцэгийн хадны зураг	Сагил сум 92 км	Хүрэл зэвсгийн үе	Аргаль, янгир сүрэглэсэн байдлаар олон тоогоор дүрсэлсэн.
15	Хад үзүүрийн хадны зураг	Бөхмөрөн сум 195 км	Хуучин чулуун.з.үе	Аргаль, янгир сүрэглэсэн байдлаар олон тоогоор дүрсэлсэн.
16	Хар цагаан усны хадны зураг	Баруунтуруун сум 235 км	Төмөр зэвсгийн үе	Буга гөрөөс, аргаль, янгир олон тоогоо дүрсэлсэн.
17	Цагаан өтөг хадны зураг	Сагил сум 81 км	Хүрэл зэвсгийн үе	Аргаль, янгир сүрэглэсэн байдлаар олон тоогоор дүрсэлсэн.
18	Шар булгийн онцын хадны зураг	Өлгий сум 139 км	Төмөр зэвсгийн үе	Улсын хагаалалтанд орж байсан.Онц сонирхолтой хадны сүг зураг бий.
19	Чандмань уулын булш	Улаангом  2.5 км	Хүрэл зэвсгийн үе	Чандмань уулын булшинд 1976 онд хийсэн археологийн малталт нь олдвороороо дэлхийн соёлын түүхэнд Чандманы соёл хэмээх шинэ нэр томъёог оруулж ирснээрээ түүхэн ач холбогдолтой.
20	Долоодойн түрэг бичээс	Увс аймгийн ОНС музейд	Түрэгийн үе	1956 онд археологич Ц.Доржсүрэн Түргэн сумын Хар ус гэдэг газраас олж аймгийн музейд шилжүүлэн авчирсан. Эртний Түрэгийн Руни бичгээр 4 мөр бичигдсэн дурсгал юм.

21	Төмөр цоргын хадны бичээс	Сагил сум Энэ газар сагил суманд байдаг боловч уг бичээс олдохгүй байгаа 86 км	Түрэгийн үе	1981 онд археологич Д.Цэвээндорж анх илрүүлэн түүхийн эргэлтэнд оруулсан. Ердөө наймхан үсэг зурлагаас бүрдсэн монголын хамгийн баруун хойд талын дурсгал юм.
22	Ачит нуурын хадны бичээс	Бөхмөрөн Баян-Өлгий аймгийн музейд 165 км	Түрэгийн үе	Ачит нуураас баруун хойшоо 17 км-т шанагын хэв гэдэг газарт оршдог. 1979 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн ЭША Н.Сэр-Оджав, Д.Дорж нар илрүүлэн тэмдэглэсэн.
23	Төгсбуянтын хүрээний туурь	Түргэн сум 99 км	1758-1938 он	Улаангомоос 99 км-т Таван Дэнхэрваан уулын ёроолд оршдог

## **Хоёр. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, ХОЛБОГДОХ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **2.1 Аялал жуулчлалын дотоод дүн шинжилгээ**

#### **2.1.1 Салбарын дүр төрх**

Увс аймаг нь байгалийн бүс бүслүүр, экосистемийн олон иж бүрдлийг агуулсан “Дэлхийн өв”-ийн өлгий нутаг.

Увс нуурын ай сав газар нь 1993 онд дархан цаазат газар, 1997 онд НҮБ-ын олон улсын шим мандлын нөөц газрын сүлжээнд, 2003 онд дэлхийн өвийн сүлжээ, 2004 онд олон улсын ач холбогдол бүхий нүүдлийн шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцид тус тус нэгдэн орсон.

Унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, хангай, говь цөл хосолсон үзэсгэлэнт сүрлэг байгаль, олон ястны өвөрмөц ахуй, зан заншил, түүх соёлын дурсгалт газрууд олон байдаг тулгуурлан, “Аялал жуулчлалыг 2015 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө”-нд Баруун бүсийг байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх сонирхол татахуйц бүс болгохоор тусгасан.

Аймгийн хувьд аялал жуулчлал нь: Увс аймгийн хөгжлийн стратегийн хөтөлбөр 2008 -2021/ Тэргүүлэх чиглэл – “Эдийн засгийн өсөлтийг хангах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, экспортын баримжаатай гол салбар болох уул уурхай, аялал жуулчлал, чацаргана, жамц давсны болон бусад ЖДҮ-ийг онцгой анхаарч таваарлаг мал аж ахуй, эрчимжсэн газар тариаланг хөгжүүлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах замаар мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох” гэж заасан.

Аймгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрт: 2001-2002 он хүртэл уламжлалт ан авлах жуулчлалын газраас янгир, угалз агнахаас гадна Ямаат, Ханхөхийн уулсаас янгир, буга, бор гөрөөсний дагнасан болон хосолсон агналтыг үржлийн нөхөн сэргээгдэх боломжид тулгуурлан хийглэх. 2011 – 2020 он хүртэл Байгалийн аялал жуулчлалыг олон улсын түвшинд явуулах хэмжээнд хүргэх. “Байгаль орчны тогтвортой хөгжил” бүлэгт- Унаган байгаль орчноо хамгаалах боломж бүхий, жуулчдын сонирхол хэрэгцээг хангахуйц аялал, жуулчлалын маршрут, чиглэлийг аймгийн болон бүс нутгийн хэмжээнд боловсруулан гаргаж, түүнийг олон улсын аялал, жуулчлалын түвшинд хүргэн тохижуулах ажлыг бүсийн аймгуудтай хамтран дэс дараатай явуулах. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудыг орчин үеийн шаардлагад нийцэхүйц болгож улмаар зэрэглэлийг ахиулан олон улсын жишигт ойртуулах зэрэг зорилтууд тусгагдсан байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт: Хартэрмис, Хэцүү хад, Цүнхэгийн амралтыг тохижуулах, Урт булаг, Шар харгай, Хүнхийн рашааныг хамгаалж, амралт сувиллын улиралын үйлчилгээ ажиллуулах, “Увс” амралт, аялал жуулчлал, рашаан сувиллын сүлжээ бий болгож, үндэсний соёл түүх, нүүдэлчний амьдралын хэв маягийг тусгасан жуулчдыг татах төслүүдийг дэмжих зорилтыг тавьжээ.

Аймгийн нутагт 1995 оны үеэс эхлэн аялал жуулчлалын компаниуд жуулчны баазууд байгуулан үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Одоогийн байдлаар 6 жуулчны бааз, амралтын газар ажиллаж байна. “ССТ-Од” ХХК Хархираа амралт жуулчлалын төвийг, “Баян барс” ХХК Хар тэрмэсийн рашаан сувиллын газруудад 30-40 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар засвар үйлчилгээ хийж, байр, гадна талбай, хоолны болон хүлээн авалтын танхимыг засварлаж, нэг ээлжиндээ 100-250 хүн хүлээн авч үйлчлэх боломжтой болсон. Хархираа, Хэцүү хад, Хар тэрмэсийн баазууд УНАСУТХГ-ын захиргаатай хамтран ажиллаж, аялал



жуулчлалын сүлжээний эхлэл тавигдсан. “Онцын тасархай” ХХК Түргэн сумын Хиргэнэд, “Аргай аз” ХХК Увс нуурын орчинд жуулчны гэр бааз барьж ашиглалтад оруулсан. Увс нуурын ай савын УТХГ-ын хамгаалалтын захиргаа онгоцны буудалд эко гэр барьж, 400 орчим гадаадын жуулчин, аймгийн төвийн 500 гаруй иргэд, үйлчлүүлсэн. Жуулчдын аяллын маршрутыг сонгосон байдлыг авч үзвэл 50 хувь нь Хархираа, Түргэн, Цагаан шувуут уулсаар, 25 хувь нь Увс, Хяргас нуур, 5 хувь нь Алтан элс, Ханхөхийн чиглэлээр аялсан байна. Аймгийн төв Улаангом хотод хэд хэдэн зочид буудал, үйлчилгээний төв нээгдэж, зочдын байрлах орны тоо 100 –д хүрч нэмэгдсэн. Аймгийн төвд 2.5 км хатуу хучилттай зам тавигдаж, шинээр 0.4 км замыг нэмж ашиглалтанд оруулсан. Улаангом-Хандгайтын чиглэлд хатуу хучилттай зам баригдаж, ОХУ-тай холбогдсоноор тэндээс ирэх жуулчид, аялагч, амрагчдын тоо нэмэгдэх нөхцөл бүрдлээ.

Аймгийн ЗДТГ-ын ҮДББОБЗ-ийн хэлтсээс авсан мэдээгээр Увс аймгийн нутагт 2006 онд 400 жуулчин, 2007 онд 660 гадаадын жуулчид шууд буюу Ховд, Баян-өлгий аймгаас дамжиж ирсэн байна. Дотоодын жуулчдын хувьд нарийвчилсан тодорхой тоо байхгүй ба Хар тэрмис, Хархираа амралтын газар, Увс нуур, Онцын тасархай гэр баазуудад 2006 онд 2300 жуулчин, 2007 онд 3100 жуулчид амрагчид амарч сувилуулсан мэдээтэй байна /график.16/.

Баруун бүсийн аялал жуулчлалын холбоог 2002 онд байгуулсан ч одоогийн байдлаар тодорхой ажил зохиогоогүй үйл ажиллагаа нь зогсонги байна. Цаашдаа уг холбоог шинэчлэн байгуулж, баруун бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэх бүсийн нэгдсэн хөтөлбөр боловсруулах, маршрут тогтоох, аялал жуулчлалын улсын сүлжээнд холбох шаардлагатай байгаа юм.

Бүсийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн хөтөлбөрт Увс аймгийг байгалийн үзэсгэлэнт газар, ховор ан амьтан түүх соёлын дурсгалуудад түшиглэн аяллын маршрутыг: дархан цаазтай газрын чиглэл, Хяргас –Айргийн хоолойн чиглэл, говь хангайн хосолсон маршрут, уулын спорт аяллын бүс, ангийн отгууд бүхий бүс, усан аяллын бүс, алдарт хүмүүсийн төрсөн нутгаар гэсэн чиглэлд аяллын маршрутыг зохион байгуулах боломжтой гэж үзсэн байна.

Хэдийгээр нөөц боломж байгаа хэдий ч орон нутгийн бололцоогоо ашиглах шинжлэх ухааны үндэслэлтэй тооцоо судалгаа хангалттай бус, жуулчдын хэрэгцээ шаадлагыг хангахуйц материаллаг бааз, нөхцөл төдийлөн бүрдээгүй, үйлчилгээний чанарын шаардлага хангалттай биш, гадаадын жуулчдыг ихэнхдээ ан агнуурын үйл ажиллагаагаар хязгаарладаг, жуулчлалын мэдээллийн сүлжээ тогтолцоо, аяллын маршрут, газрын шинэчилсэн зураггүй байгаа зэрэг дутагдлуудаас хамааран аялал жуулчлалыг зохих түвшинд хөгжүүлэх бололцоо бүрдэхгүй байна.

### 2.1.2 Нөхцөл байдлын шинжилгээ

Увс аймгийн аялал жуулчлалын өнөөгийн нөхцөл байдал болон аймгийн нутаг дэвсгэрт хийсэн судалгааны баримт мэдээлэлд тулгуурлан SWOT шинжилгээний аргаар аялал жуулчлалыг хөгжүүлэх давуу болон сул тал, таатай боломж болон эрсдэлийг авч үзлээ.

#### Давуу тал:

- Байгалийн бүс бүслүүр, экосистемийн олон иж бүрдлийг агуулсан “Дэлхийн өв” нутаг
- Мөнх цаст өндөр уулс, ойт хээр, хээр, говь цөлийн бүсэд шилжих байгалийн олон бүс бүслүүрийг хамран оршиж байгаа нь аялал жуулчлалын олон төрөл, хэлбэрийг хөгжүүлэх
- Явган аялал явуулах байгалийн сайхан тогтоцтой /Хархираа-Түргэн-Цагаан Дэглий/
- УНАСДЦГ-ын Хархираа, Түргэн, Дэглий цагаан уулс нь эгц хажуутай, мөсөн голын хөндий, цавчим хадан хясаа бүхий авиралтын хүнд нөхцөлтэй нь адал явдал, эр зоригийн уулын аяллыг хөгжүүлэх
- Цэнгэг агаартай, цэлмэг өдрийн тоо олон тул шөнийн оддыг ажиглах
- Өргөн уудам нутаг, онгон зэрлэг байгальтай. Дэлхийн улаан номонд орсон нэн ховор ирвэс болон алтайн аргаль, угалз, янгир, тэх, буга зэрэг өндөр уулын ховор ан амьтантай нь гадаадын анчин жуулчдын сонирхлыг татах тул ан агнуурын аяллыг хөгжүүлэх
- Монгол орны хамгийн том нуур болох дархан цаазат Увс нуураар аялах, усанд сэлэх, шувуудын цуглааныг үзэх, дэлхийн бөмбөрцгийн хамгийн хойд захын элстэй цэг болох Алтан элсийг үзэх зэрэг дахин давтагдашгүй өвөрмөц гайхамшгийг аяллын нэг маршрутаар үзэх ховорхон боломжтой
- Хяргас нуурын сувилалд амрах, усанд сэлэх, наранд шарах их элсэн хаялгатай ба загасчлах, хар галуу, цахлайн өвөрмөц амьдралтай танилцах
- Түүх соёлын дурсгалт газар олонтой
- Нүүдлийн соёл иргэншил, ахуйг өнөөг хүртэл хадгалсан олон ястны уламжлал зан заншил бүхий нутаг

#### Сул тал:

- Монгол орны баруун хойд хэсэгт орших бөгөөд улсын нийслэлээс алслагдсан тул аялал жуулчлалын нөөцийг зах зээлийн эргэлтэнд оруулах боломж хязгаарлагдмал
- Дэд бүтэц, зам тээврийн сүлжээ муу, хэт алслагдсан тул үүнээс шалтгаалан аяллын зардал өндөр, хугацаа урт байдаг нь хямд аялах сонирхолтой жуулчдын хувьд бэрхшээлтэй
- Жуулчны бааз, шаардлага хангах үйлчилгээний иж бүрэн байгууламж, материаллаг бааз хангалтгүй
- Экологийн хувьд эмзэг
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, даац нь бүрэн тогтоогдоогүй
- Аялал жуулчлалын удирдлага зохион байгуулалтын бүтэц бүрдээгүй, мэргэжлийн боловсон хүчин дутмаг, нутгийн захиргааны байгуулагад нь аялал жуулчлалын мэргэжилтэн дагнан ажилдаггүй
- Аялал жуулчлалын мэргэжилтэй ажилчид /хэлмэрч, тогооч, үйлчлэгч, газарч бэлтгэгдээгүй

- Байгаль орчин, ан амьтан, ургамал, зах зээлийн талаар хийсэн орон нутгийн суурь судалгаа дутмаг
- Орон нутгийн онцлогийг тусгасан бэлэг дурсгалын зүйлсийн үйлдвэрлэл, борлуулах нэгдсэн сүлжээ байхгүй
- Баруун аймгуудын хэмжээнд нэгдсэн маршрут сүлжээ гараагүй, хамтран томоохон сурталчилгаа хийх боломж хомс, төрөлжсөн зар сурталчилгааны ач холбогдлыг үнэлдэггүй
- Гадаадад шууд нислэггүй, орон нутгийн нислэг 7 хоногт 1-3 нислэгээр хязгаарлагдсан.
- Замын тэмдэг тэмдэглэгээ хийгдээгүйгээс очих газрын баримжаагүй
- Аялал жуулчлалын улирал богино

#### **Боломжит нөхцөл:**

- Монгол улс аялал жуулчлалын зорих газар хэмээн дэлхийд танигдах болсон нь манай улсыг зорин ирэх гадаадын жуулчдын тоо нэмэгдэхэд нөлөөлж байгаа
- Олон улсын хэмжээнд идэвхитэй болон тусгай сонирхолын аяллын хэлбэрүүд тухайлбал: явган болон морин аялал, малчин айлын ахуй амьдралын хэв маягтай танилцах, суралцах аялалд оролцогчдын тоо өсөн нэмэгдэж байгаа
- Гадаргын олон хэлбэрт хэв шинжийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон зөв зохистой ашиглах
- Байгаль орчинд эвсэг аяллыг нутгийн иргэдэд түшиглэн зохион байгуулж, тэднийг ажлын байр, орлогын эх үүсвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх
- Ховд их сургууль, Улаангом коллежийг түшиглэн аялал жуулчлалын мэргэжилтэй ажилтанг бэлтгэх
- Баруун бүсийн аялал жуулчлалын холбоо, НИТАЖ-д түшиглэн мэдээлэл түгээх, сургалт сурталчилгааны нэгдсэн сүлжээг үүсгэх, хөгжүүлэх
- Олон улсын аялал жуулчлалын байгууллага, агентлагын гишүүнээр элсэж, олон талын хөнгөлөлт эдлэх, сурталчилгаа хийх боломжыг нэмэгдүүлэх
- Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Чацаргана, жамц давс зэрэг брэнд аялалыг зохион явуулах боломжтой
- Ховд-Улаангомын чиглэлд өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ байгуулахаар баруун бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан /интернетийн сүлжээний боломжийг орон нутгийн түвшинд ашиглах/
- Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 19.7% нь ТХГН-ын сүлжээнд хамрагдсан учир УНАСТХГ-ын болон бусад төслүүдийг хамтран хэрэгжүүлэх боломж өндөр, НИТАЖ-ын сүлжээнд хамрагдсан
- Дотоодын аялагчдын тоо сүүлийн жилүүдэд ихээхэн өсөж байгаа

#### **Эрсдэл:**

- Ховор амьтдын өлгий нутгийн аялал жуулчлалын бүсэд аялал жуулчлалын нөөц төвлөрсөн байгаа нь нөөцийн хэт ачааллаас үүдэж элэгдэл эвдрэлд орох, бүсийн хөгжлийн тэнцвэргүй байдал үүсэх
- Буруу менежмент, хэт ачааллаас хамгаалалттай бүс нутаг, байгалийн нөөц, үзмэрүүд өртөж, сүйдэх
- Эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай тул байгалийн гэнэтийн үзэгдэлд /цочир хүйтрэл, ган, үер, шороон шуурга/ өртөх магадлал өндөр
- Аялал жуулчлалын үзмэрүүдэд хадгалалт хамгаалалт дутагдан элэгдэж муудан ач холбогдол нь буурах
- Гадаргын хэвгий хэрчигдэл нь дэд бүтцийн хөгжилд сөргөөр нөлөөлөх



- Малчдын уламжлалт соёл, зочломтгой чанар, нүүдэлчний соёл иргэншил өөрийн дүр төрхөө алдаж болзошгүй
- Хувиараа алт олборлогчид байгалийн унаган төрхийг хөндөх, байгаль орчины экологийн тэнцвэрийг алдагдуулах
- Ойн түймэр, хулгайн ан, хууль бусаар мод бэлтгэх болон хог хаягдын зохицуулалтгүй байдал зэрэг нь байгаль орчны доройтлыг бий болгох
- Дотоодын жуулчдын эмх замбараагүй, хяналт зохицуулалтгүй байдал

Дээрхи SWOT шинжилгээнд үндэслэн давуу талыг ашиглан таатай боломжуудыг нэмэгдүүлэх, сул талаа хянах, багасгах арга замыг тодорхойлон учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тооцох нь аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхэд ач холбогдолтой.

### 1.1.3. Аялал жуулчлалын хэрэгцээний статистик дүн шинжилгээ

Монголын аялал жуулчлалын эрэлт хэрэгцээний тухай мэдээллийн дүн шинжилгээний анхдагч эх үүсвэр болох Монголын аялал жуулчлалын жилийн эмхэтгэлээс үзэхэд аяллын оргил үе нь 4-10 сар хүртэл байгаа бөгөөд үүнээс 5-9 саруудад өндөр байна. Аймгийн хамгийн том Боршоогийн боомтыг Бургастайн боомттой харьцуулан авч үзлээ. Бургастайн боомтоор нэвтэрсэн орсон хүний тоо өмнөх онтой харьцуулбал 5117-р өсөж 2006 онд 12088, гарсан хүний тоо 4989-р өсөж 11451 болсон байна /График.10/. 2006 онд Боршоогийн боомтоор нэвтэрсэн /орсон/ зорчигчдын тоог аяллын зорилгоор нь авч үзвэл /График.11/ хувийн журмаар 51% буюу 6060 хүн, байнга оршин суух 38% буюу 4587 хүн, албан ажлаар 11% буюу 1276 хүн нэвтэрсэн байна. 2006 онд Боршоогийн боомтоор нэвтэрсэн /гарсан/ зорчигчдын тоог аяллын зорилгоор нь авч үзвэл /График.12/ хувийн журмаар 5781 хүн, албан ажлаар 79 хүн, байнга суух 10 хүн, жуулчлал 9 хүн, бусад зорилгоор 9 хүн нэвтэрсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын ҮДББОБЗ-ийн хэлтсээс авсан мэдээгээр Увс аймгийн нутагт 2006 онд 400 жуулчин, 2007 онд 660 гадаадын жуулчид шууд буюу Ховд, Баян-өлгий аймгаас дамжиж ирсэн байна. Дотоодын жуулчдын хувьд нарийвчилсан тодорхой тоо байхгүй ба Хар тэрмис, Хархираа амралтын газар, Увс нуур, Онцын тасархай гэр баазуудад 2006 онд 2300 жуулчин, 2007 онд 3100 жуулчид амрагчид амарч сувилуулсан мэдээтэй байна.



## 2.2 Аялал жуулчлалын суурь нөөцүүд, тэдгээрийн үнэлгээ

Аялал жуулчлалын суурь нөөц гэдэгт Увс аймгийн нутаг дэвсгэр дэх түүх соёлын дурсгалт, байгалийн үзэсгэлэнт газрууд, ховор ан амьтан ургамал, рашаан, олон ястны уламжлалт өвөрмөц ахуй соёл, зан заншил, тэмдэглэлт үйл явдлууд зэрэг аялал жуулчлалд ашиглагдах нөөцүүдийг авч үзсэн.

Увс аймгийн нутаг дэвсгэр дэх байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газруудын онцлог өнөөгийн байдлыг дараахи хүснэгтэд харуулав.

Аймгийн нутаг дэвсгэрт тогтмол зохион байгуулдаг баяр нь Монголын Цагаан сар, Улсын баяр наадам, сумын наадам юм.

№	Газрын нэрс	байршил	онцлог	өнөөгийн байдал, үнэлгээ
1	Чандмань уул	Аймгийн төв Улаангом сумын баруун урд хэсэгт оршино. 2.5км зайтай.	Хаанаас ч харсан хэлбэр дүрсээ алддаггүй өвөрмөц сонин тогтоцтой улаан өнгөтэй уул. Хүрлийн хожуу, төмрийн түрүү үеийн МЭӨ 7-3-р зууны үеийн булш, эртний түүх соёлын эд өлгийн зүйлс бүхий археологийн ач холбогдол бүхий уул. 1976 онд хийсэн археологийн малталт нь олдвороороо дэлхийн соёлын түүхэнд “Чандманий соёл” хэмээх шинэ нэр томъёог оруулж ирсэнээрээ түүхэн ач холбогдолтой. Чандмань уулын рашаан тунгалаг устай гидрокарбонат, сульфат, магникальцит төрлийн хүйтэн рашаан. Ходоод, гэдэс, дотрын өвчнийг анагаадаг	Дотоодын аялагчдын ихэвчлэн зорин очдог газар. Уулын оргилоос аймгийн төвийг ажиглан харах боломжтой. Хүмүүсийн үйл ажиллагаанд ихээхэн өртөгдсөн. Орчны бохирдол хог хаягдал нэмэгдэж байгаа төдийгүй голын ус, рашааны ундарга багасаж байгаа
2	Увс нуур	Их нууруудын хойд хагаст, аймгийн зүүн хойд хэсэгт Давст, Малчин, Наранбулаг, Тариалан сумдын нутагт д.т.д 759м өндөрт оршино. Аймгийн төвөөс	Монгол орны хамгийн том нуур. Урт нь 84км, өргөн 79км, гүн нь 12-15м, 3350ам.дөр.км талбайтай. Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг. 1993/1995 онд ДЦГ болгосон. 1997 онд НҮБ-ын олон улсын шим мандлын нөөц газрын сүлжээнд, 2003 онд дэлхийн өвийн сүлжээ,	ДЦГ. Байгалийн болон эрдэм шинжилгээний аялал жуулчлал явагддаг. Нуурын төрх байдлыг ажиглах, усанд сэлэх, наранд шарах, завиар аялах, усны шувуудыг ажиглах зэрэг гадаадын болон дотоодын аялагчдын зорин очдог газар.

		40 км зайтай	2004 онд олон улсын ач холбогдол бүхий нүүдлийн шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцид тус тус нэгдэн орсон. Шувуудаас 345 зүйл, өвөлждөг 8 зүйл, дайрч өнгөрдөг 82 зүйл бүртгэгдсэн. Хун, цаст дэглий, халбаган хошуут, галуу, ногтруу гэх мэт	Давстай нуур тул янз бүрийн арьсны өвчин эмгэгийг анагаадаг. Ойролцоо нь “Увс нуур” жуулчны баазтай. Зуны улиралд өдрийн амрагчид ихээр очдог. Судлаачил 4-5 хэсэгт шувуу ажиглах цэгийг тогтоосон. хүмүүсийн үйл ажиллагаанд багавтар өртөгдсөн ч хог хаягдал нэмэгдэх болсон
3	Алтан элс	Увс нуурын хотгорын зүүн хэсэг, Бөөрөг дэлийн элсний зүүн хэсэгт Баруунтуруун сумын нутагт оршино. хө 49° 55 <sup>1</sup> , зу 94° 50 <sup>1</sup>	177.5 мянган га талбайтай дов толгодлог гадаргатай. Элсэн доороос эх аван урсдаг цэнгэг устай гол горхи, булаг шанд баян бүрдтэй байгалийн үзэсгэлэнт газар. Сөөгөнцөр, үетэн, алаг өвс бүхий бүлгэмдэл зонхилно. Элсний урд хаяа дагуу нарс, шинэс, чацаргана ургадаг. Эмийн ургамалтай. Суусар, туулай, тарвага мануул, үнэг байхаас гадна улирлын байдлаас болж усны шувууд ирдэг	ДЦГ. Гадаад дотоодын жуулчид говийн их элсэн дундах баян бүрд, дэлхий хамгийн хойд захын элсийг үзэхээр зорин ирдэг. Тэмээн аялал, байгалийн аялал. Хүмүүсийн үйл ажиллагаанд бага өртөгдсөн
4	Дөрөө нуур	Аймгийн зүүн хэсэгт Бөөрөг дэлийн элсний зүүн жигүүр Баруунтуруун сумын нутагт оршино	Монгол улс, Орос улсын хилийн заагт байрласан. 20 ам.дөр.км талбайтай. Загасчлах боломжтой.	Загасчлах аялал. Хил дамнасан аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдөж байгаа. Хилийн бүсэд байрлах тул янз бүрийн байгаль орчны зөрчил ихсэх хандлагатай
5	Хяргас нуур	Их нууруудын хотгорт Хан Хөхийн нурууны урд хэсэгт Завхан,	д.т.д 1028м өндөр, 75км урт, 31км өргөн, 80м гүн, 1406.8км талбайтай нь нийт цогцолбор газрын 31.4%	Ханхөхий-Хяргас нуурын БЦГ-ын аялал жуулчлалын гол түшиц газар. Дотоодын аялагчдын

		Наранбулаг, Цагаанхайрхан, Малчин, Хяргас сумын нутагт оршино	эзлэнэ. Эргийн шугам хэрчигдэл ихтэй. 2000 онд УТХ авсан. Улаан номд орсон олон төрлийн шувуу, загас амьдардаг. Хар Тэрмисийн рашаан нь гидрокарбонат, сульфат, магни, кальцитийн найрлагатай ходоод, элэг, цөс, бөөрний өвчнийг ангаана. Шавар эмчилгээтэй, усанд орох, наранд шарах элсэн хаялагтай, загасчлах боломжтой	зорин очдог гол газар бөгөөд дэргэдээ рашаан сувилалтай. “Хэцүү хад” жуулчны баазтай. Хяргас айраг нуурын хоолой нь өвөрмөц тогтоцтой загасчлах боломжтой. Шувуу ажиглах цэгтэй. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдсөн
6	Хэцүү хад	Хяргас нуурын зүүн хөвөөнд Завхан сумын нутагт оршино. Аймгийн төвөөс зүүн урд зүгт 230км, Завхан сумаас 60км зайтай	Говь хээрийн байгалийн үзэсгэлэнт газар байрладаг. Харьцангуй богино зайнд 5-7км хадархаг, цохио, өндөр хадан хясаа бүхий ургамал амьтны өвөрмөц чуулбар хэсэг. Хар галуу, цахлайн өвөрмөц амьдрал, зан төрхийг харах боломжтой. Алтайн сугас, монгол хадран, осмон, шар загастай	БЦГ. Гадаад дотоодын жуулчид их очдог. Загасчлах, морь, тэмээн аялал /шувуудын цуглааныг ажиглах, загасчлах/ “Хэцүү хад” жуулчны баазтай. Шувуудын цугларалт, байрлалд сөрөг нөлөөлөл гарах хандлагатай. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдөж байгаа
7	Гоожуурын хүрхрээ, Олон нуур	Ховд сумын нутагт Хархираа, Түргэний уулсын баруун урд оршино	Байгалийн үзэсгэлэнт газар. Гоожуурын хүрхрээ 17м өндрөөс унана. Олон нуурын уулс нь д.т.д 3000м өндөр. Мөнх цас, сүрлэг хад уулс, улаан номд орсон нэн ховор ирвэс, аргаль, янгир, буга зэрэг 20 зүйлийн ан амьтан, 30 гаруй зүйлийн ургамалтай. Том жижиг 108 нууртай. Шар, ногоон, сүүн цагаан зэрэг олон өнгөтэй. Вансэмбэрүү цэцэг харах боломжтой	Улсын тусгай хамгаалалтанд авсан. Байгалийн аялал жуулчлалын гол түшиц газар. Гадаадын жуулчдын төрөл бүрийн аяллын хэлбэрт багтдаг. Сүүлийн жилүүдэд хүрхрээний ус багасах хандлагатай болсон. Хүмүүсийн үйл ажиллагаанд бага өртөгдсөн
8	Цагаан шувуут уул	Увс нуур, Үүрэг нуурын усан сан хагалбарт зүүн хойноосоо баруун урагш сунаж тогтсон	Сагиль сумын нутагт 22 мянган га талбайг хамрана. Увс нуурын ай савын өндөр уулын нуга, уулын хээрийн онцлогийг төлөөлнө. д.т.д 3496м	УТХ-д авсан. Гадаадын жуулчдын төрөл бүрийн аяллын хөтөлбөрт байнга багтдаг. Түүх соёлын дурсгалт газартай.



		байршилтай. хө 50°20', зу 91°00'	өндөр, хэрчигдэл ихтэй, шовх хянга, хад асга бүхий эгц хажуутай. Уулын хүрэн хөрс зонхилох ба өндөр уулын тачир сийрэг ургамал бушилж, улалж, хаг хөвд голлоно. Цагаан шувуут уулын кластерт 72 зүйл хөхтөн амьтад бий. Ирвэс, аргаль, янгир, хүдэр, халиун буга, хар сүүлт зэрэг монголын улаан номд орсон ховор амьтад бүхий байгалийн үзэсгэлэнт газар	Баянөлгий, Ховд аймаг руу дамжин өнгөрөх бүс учир ан амьтан дайжих, хог хаягдал нэмэгдэх хандлагатай. Хилийн бүстэй ойрхон учир хилийн зөрчил, малын хулгай гарах эрсдэлтэй. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдөж байгаа
9	Үүрэг нуур	Сагиль, Түргэн сумын заагт Цагаан шивээт, Түргэн уулсын хоорондох 1426м өндөрт оршдог	18км өргөн, 19км урт, 42м гүн, 237 ам.дөр.км талбайтай техтоник гаралтай давстай нуур. Цагаан гол, Цагдуулт, Хариг зэрэг голууд цутгадаг. Алтайн сугас, монгол хадран, осмон, нохой загас зэрэг загастай	Гадаад дотоодын жуулчид очдог. Байгалийн болон загасчлах аялал, шувуу ажиглах. Дамжин өнгөрөх бүс учир нуурын эрэг орчмоор хог хаягдал ихсэх хандлагатай. Хүмүүсийн үйл ажиллагаанд бага өртөгдсөн
10	Шүдэн уул	Давст сумын төвөөс зүүн зүгт 18 км-т оршино	Тус давсны ордын нөөц нь 73.2 сая тонн. Давсны зузаан нь 9-50м. Тус давсны уурхайг 1974 оноос ашиглаж эхэлжээ. Шүдэнгийн жамц давс хүнсэнд болон малын тэжээлд тохиромжтой	Дотоод гадаадын аялагчид давсны өвөрмөц тогтоц, давс олборлох аргатай танилцахаас гадна байгалийн үзэсгэлэнт Торхилог голоор аялана. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдсөн
11	Төгсбуянтын хүрээний туурь	Түргэн сумын нутагт Түргэн, Буурлын голуудын бэлчирт байрлана	Дөрвөд далай ханы гол хүрээ ба 1758 онд суурийг нь тавьсан. Чогчин, Жүд, Мамба, Чойр, Дуйнхор гэсэн 5 том дацан, 22 сүм дуган, 800 гаруй ламтай байжээ. 1938 онд уг хийдийг тараажээ. Таван Дэнхэрваа уулын хажууд одоо зөвхөн туурь үлджээ	Гадаадын жуулчдын морин ба явган аялал энэ орчмоор явагддаг. Ойролцоо нь “Онцын тасархай” жуулчны баазтай. Түргэн сумын хуучин төв Баянхайрхан багийн төв. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдсөн

12	Түргэн уул	Түргэний уулс нь Ховд, Түргэн, Бөхмөрөн, Сагил сумын нутгийг дамжин 70 орчим км үргэлжилнэ	1993 оноос УТХ-д авсан. Буурал, Түргэн, Живэртэйн голуудын эх авсан нуруунуудыг дамжуулан Цагаан дэглий уулнаас зүүн тийш Хавцалын боом хүртэлх 145.1 мянган га талбайг хамрана. Уулын тундр, ой, тайга, уулын хээр зэрэг байгалийн олон бүс бүслүүр хосолсон мөнх цас, мөсөн тогоо, хүрхрээ, агуй, хад цохио бүхий байгалийн үзэсгэлэнт газар. Түргэний уулсаас Хархираа, Түргэн, Ямаат гол эх авч урсдаг. Хар мод бургас, бушилж ургана. Ирвэс, аргаль, янгир зэрэг 30 гаруй зүйлийн ан амьтантай. Оргил нь “Дэглий Цагаан” 4096м өндөр. Уулын спортыг хөгжүүлэх боломжтой	УТХ-д авсан. Гадаадын жуулчдын төрөл бүрийн аяллын хөтөлбөрт багтдаг аялал жуулчлал хөгжүүлэх гол түшиц газар. Явган, морин, тэмээн аялал ихэвчлэн явагддаг. Онцын тасархай, Хархираа жуулчны бааз, Цүнхэгийн амралт энэ бүсэд байрладаг. Малчдын “Гурван хороо”, “Ямаат”, “Олон нуур” аялал жуулчлалын нөхөрлөл байрладаг. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдөж байгаа
13	Ямаат уул	Аймгийн баруун хойд хэсэгт Бөхмөрөн, Ховд сумын нутгийг дамжин оршино	Мөнх цас, мөсөн оргил бүхий байгалийн үзэсгэлэнт газар. Ямаат уул д.т.д. 3900м өндөр. Зүрхэн уул, Их Ямаат, Бага Ямаат, Ирвэстэй, Хонжиг, Рашаантын ам зэрэг уулс нь ховор ургамал амьтны өлгий нутаг. Дэлхий улаан номд орсон нэн ховор ирвэс, аргаль, янгир, шилүүс гэх мэт 30 гаруй зүйлийн ан амьтантай. Алтангагнуур, Вансэмбэрүү зэрэг ховор ургамалтай төдийгүй хүрлийн үеийн хадны зураг түүх соёлын дурсгалтай	УТХ-д авсан. Байгалийн аяллын гол түшиц газар. Морин аялал, явган аяллын гол бүс. Гадаадын жуулчдын төрөл бүрийн аяллын хөтөлбөрт багтдаг. Ямаат нөхөрлөлийн гэр бааз байрладаг. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдөж байгаа
14	Баян нуур, Урт булагийн рашаан	Зүүнговь сумын нутаг Бөөрөг дэлийн элсний хойд хэсэгт оршино	Цэнгэг устай нуур. Урт нь 11.5км, өргөн нь 3.9км, 27.8 ам.км талбайтай. Баян нуурын усан хоолойд усанд орох боломжтой. Нуурын баруун хойт зүгт	Гадаад дотоодын жуулчид зорин ирдэг. Тэмээн аялал, байгалийн аялал, эмчилгээний аялал. Орон нутгийн

			Урт булагийн рашаан бий. Баяннуураас Урт булаг 10км зайтай. Өвөлд хөлддөггүй, гидрокарбонат, кальц-натрит төрлийн рашаан. Ходоод, гэдэс дотор, бөөрний өвчнийг анагаана	чанартай рашаан сувилал ажиллаж байсан. Одоо зуны цагт нутгийн иргэд хувиараа майхан гэр барьж рашаан ууж амардаг. Хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдөж байгаа
15	Зураагийн хадны зосон зураг	Зүүнхангай сум 351 км	Овог отгоороо ан хийж байгааг дүрсэлсэн чулуун зэвсгийн үеийн зураг дэлхийд 2 байдаг. Нөгөө нь Америкийн Аляскт бий	Наран тал руу харсан тул нар салхи, ус бороо зэрэг байгалийн элэгдэлд орж дүрс тэмдэг нь илт бүдгэрсэн. Хамгаалах шаардлагатай
	Можоогийн хадны зураг	Сагил сумын нутаг 111 км Цагаан голын эхэнд оршино	Неолитийн үеийн дурсгал. Монголд төдийгүй дэлхийд гайгахдах дурсгал хэмээн үздэг. Монголд 2 байдаг нөгөө нь Ховдын Гурван цэнхэрийн агуйн зураг. Можоогийн хадны зурагт аргаль, янгир, тэмээ, нохой, үхэр, хүн зэргийг дүрсэлсэн. Үхрийг нум сумаар харваж байгаа болон хөтлөн явж буй хүнийг дүрсэлсэн	Нутгийн иргэдийн дунд түүх соёлын дурсгалыг хамгаалах, түүхэн үнэ цэнийг нь алдагдуулахгүй байх хамгаалалтын шинэ арга замыг тодорхойлох шаардлагатай

Аймгийн аялал жуулчлалын үйл ажиллагааг голлон явуулах газруудад үнэлэлт өгөхдөө байгалийн нөхцөл, нөөцийг бүхэл бүтэн тогтолцооны хоёр тал гэж үзээд хамтатган авч үнэлэх нь ихээхэн ач холбогдолтой юм. Энэ үнэлгээг хийхийн тулд байгалийн нөхцөл, нөөцийг нөлөөлөх байдлаар нь:

1. Хүний оюуны алжаалыг тайлж, сэтгэл зүйн шинэ мэдрэмж төрүүлж, байгалийн гоо сайхныг бишрэх, сэтгэл ханамж өгч, биеийн эрүүл мэндийн байдалд эерэгээр нөлөөлөх нөхцөл, нөөц /агаарын хэм, харьцангуй чийгшил, агаарын даралт, нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа, цэлмэг нартай өдрийн тоо, салхины горим, гадаргын олон хэлбэр, байгалийн олон бүс бүслүүрийн хослол, ус, ургамал амьтны бүрдэл/

2. Амралт, эмчилгээ сувилал, аялал жуулчлалыг зохион байгуулж, хүний биеийн алжаалыг тайлж, эрүүл мэндийг нөхөн сэргээх нөхцөл, нөөц /гадаргын олон хэв шинж, түүнтэй уялдсан мөнх цас, мөсөн гол, ян сарьдаг, ой мод, бутлаг ургамал, нуга, уулын хээр, усан сүлжээ-нуур, гол, рашаан, элс / гэж 2 хувааж үзсэн.

Увс аймгийн хувьд дээрх байгалийн нөхцөл, нөөцийн аль алинийг нь ашиглах боломжтой боловч, оюуны алжаал тайлж, сэтгэл зүйн таашаал авах нөөц илүү гэж үзэж болно. Одоогоор хүнд үйлдвэр хөгжөөгүй учраас цэвэр агаар, цэнгэг усны нөөцтэй, гадаргын олон хэв шинж хосолсон баянбүрд, ховор ургамал, ан амьтан зэргээрээ байгалийн аялал жуулчлал давуу хөгжих боломжтой.

Увс аймгийн байгалийн аялал жуулчлалын нөөцийн үнэлгээ хийхдээ дараахи шалгуур үзүүлэлтийг баримталсан.

АНУ-ын эрдэмтийн жуулчдаас авсан судалгаагаар байгалийн завсрын бүсүүдэд жуулчид илүү их татагддаг болох нь тогтоогджээ. Тухайлбал гадарга, усан хангамж, ургамалшилтын хослолыг үндэс болгож байгалийн цогцолборыг дараах байдлаар үнэлсэн.

№	Байгалийн цогцолборын хослол	үнэлгээ /балл/
1	Ой-ус	4
2	Ой /тал хээр/-ус	3
3	Ой-нуга /тал хээр/	3
4	Бутлаг төгөл-нуга	3
5	Ой бутлаг төгөл	2
6	Тал хээр-нуга	1

Түүнчлэн ОХУ-ын Москвагийн их сургуулийн эрдэмтэд болох Н.С. Мироненко, Ч.Т.Твердохлебов нар байгалийн аялал жуулчлалд үзүүлэх нөлөөллийг газрын гадаргын хэв шинж, усан хангамж /1ам.км талбайд хэдэн км гол, горхийн урт ноогдох/ ургамалшилтаар төлүүлэн нэн тохиромжтой /5балл/, тохиромжтой /4балл/, харьцангуй тохиромжтой /3балл/, тохиромж муутай /2балл/, тохиромжгүй /0балл/ гэж ангилжээ. Бид байгалийн хослолын давуу үнэлэгдэх үзэл баримтлалыг гол шалгуур болгож байгалийн аялал жуулчлалын чиглэлээр нутаг дэвсгэрийн ялгааг гаргасан болно.

**Увс аймгийн байгалийн аялал жуулчлалын  
нөөцийн үнэлгээ /баллаар/**

№	Байгалийн цогцолбор	Хамрах нутаг	Үнэлгээ	Чиглэл, хэлбэр
1	Мөнх цас-ян сарьдаг, хадан халил-бутлаг модлог ургамал-нуга, уулын хээр, нуур, рашаан, гол, ус	Хархираа, Түргэн, Дэглий цагаан, Цагаан шувуут, Алтан хөхийн уулс, Үүрэг, Ачит нуур, Цагаан гол, Хаирг, Цагдуулт, Хархираа, Хөндлөн Боршоо голын сав нутаг	5 /нэн тохиромжтой/	Байгалийн, адал явдлын, явган аялал
2	Уулын тал-модлог, бутлаг ургамал, нуга, уулын хээр, хээр, элс, нуурын ус, рашаан	Хан-Хөхийн нуруу, Зүүн хөхий, Баруун хөхий, Цагаанхайрхан, Тогтохын шил, Хяргас нуур, Зүүн-Баруун туруун, Таван бэлчирийн голын сав нутаг	4 /тохиромжтой/	Эрүүлжүүлэх, байгалийн амралт болон угсаатны аялал жуулчлал
3	Хээр-хуурай хээр /говь/-элс-нуур-гол ус /баян бүрд, рашаан/	Увс, Дөрөө, Баян нуур, Алтан элс, Тэсийн голын адаг, дунд хэсэг, Нарийн, Сагил, Тээлийн голын адаг	4 /тохиромжтой/	Байгалийн амралт, эрдэм шинжилгээний аялал
4	Хээр-хуурай хээр, элс, баян бүрд	Хан хөхийн зүүн урд нам уулс, толгодорхог тал, хуурай хээр, элс баянбүрд бүхий нутаг	3 харьцангуй тохиромжтой	Түүх, соёл, малчдын нүүдлийн соёл
5	Толгодорхог тал-хуурай хээр-элс	Дамжигийн элс, Бөөрөг дэлийн элс, Хяргас нуураас баруун тийш орших хуурай хээр	2 тохиромж муутай	Адал явдал, экспедиц

Байгалийн гоо зүйн үнэлгээ өгөхийн тулд байгалийн экзотик шинжийг бүрдүүлдэг ландшафтын ялгааг нарийн авч үзэх нь чухал.

Байгалийн экзотик шинж төрх нь:

1. Хотгор гүдгэрийн өвөрмөгц сонин тогтоц
2. Ландшафтын олон хэв шинж
3. Тэдгээрийн орон зайн хувьд бага талбайгаар тархах
4. Өндрийн зөрүү, түүнийг дагсан байгалийн бүс бүслүүрийн эрс ялгарал
5. Ялгарал бүхий орчиндоо дасан зогицсон хөрс, ургамал, амьтны аймгийн бүрдэл
6. Хүний сэтгэлийг хөдөлгөж, байгалийн гоо сайхны мэдрэмж төрүүлэн аялагч жуулчинд сэтгэл ханамж төрүүлж байгаагаар тодорхойлогдоно.

## 2.3 Үйлчилгээний хангамж

### 2.3.1 Байрлуулах үйлчилгээ

Тус аймгийн нутагт 1995 оны үеэс эхлэн аялал жуулчлалын компаниуд жуулчны баазууд байгуулан үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Одоогийн байдлаар 6 жуулчны бааз, амралтын газар ажиллаж байна. Хан хөхий Хяргас нуурын байгалийн цогцолборт газарт “Хэцүү хад”, “Хар Тэрмис” жуулчны бааз, Хархираа, Түргэний уулсад “Онцын тасархай”, “Хархираа” жуулчны бааз, “Увс нуур” жуулчны баазууд үйл ажиллагаагаа явуулж байна. Сумдын тамгын газрын дэргэд дэн буудал ажилладаг.

Аймгийн хэмжээгээр жуулчин хүлээн авах байрлуулах үйлчилгээний талаар нэгдсэн нарийвчилсан судалгаа хийгдээгүй байна. Энэхүү хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн судалгаа болон аймгийн мэдээлэлд үндэслэн жуулчдыг хүлээн авах байр сууцны үйлчилгээний хангамж, хүчин чадлыг авч үзье.

а). Зочид буудал:

Одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан 65 гаруй ор бүхий 3 зочид буудал аймгийн төвд байна.

№	Буудлын нэр	Хүчин чадал	Бусад үйлчилгээ	Байрлал	Утас
1	ССТ-Таван Од	20	Ресторан, саун, үсчин, биллъяард, хүнсний дэлгүүр	10 жилийн 3-р сургуулийн дэргэд	39-82 34-09
2	Баялаг-Од	20	Ресторан, баар	Хаан банкны эсрэг талд	24-45
3	Увс нуур	15	Ресторан	Шуудан Холбооны өмнө	40-66

б). Жуулчны бааз:

Одоогийн байдлаар Хэцүү хад, Увс нуур, Онцын тасархай, Хархираа, Хар тэрмис жуулчны баазууд үйл ажиллагаагаа явуулж байна.

270 ор бүхий 5 жуулчны баазтай.

в). Амралт сувиллын газрууд:

Хяргас нуурын Хар тэрмис амралтын газар, Цүнхэгийн амралт, Хархираа хүүхдийн зуслан үйл ажиллагаагаа явуулж байна. Амралт сувиллын газрууд нь 6-9 сард бүрэн хүчин чадлаараа ажиллаж өвлийн улиралд хаадаг. Заримдаа 50 %-ийн хүчин чадалтайгаар ажилладаг.

### 2.3.2 Хоол ундааны үйлчилгээ

Жуулчны баазууд болон, амралт сувиллын газар, Улаангом сумын хоол ундааны хангамж, хүчин чадлын хувьд дараах байдалтай тодорхойлогдож байна.

а). Улаангом сумын төвд байрлах ресторан, хоолны газрууд

№	Зоогын газрын нэр	Хүчин чадал	Байрлал
1	ССТ-ын Баялаг	100 хүн	10 жилийн 3-р сургуулийн дэргэд
2	Хан хөхий	100 хүн	Аймгийн татварын хэлтэсийн дэргэд
3	Маргад	100 хүн	Ардчилал ордны дэргэд
4	Баялаг Од	50 хүн	Хаан банкны эсрэг талд

Дээрхээс гадна Их Монгол, Билэг, Чингис, Монгол зоог зэрэг нэг ээлжиндээ 40 хүн хүлээн авах хүчин чадалтай кафе үйл ажиллагаагаа явуулж байна.

Жуулчны баазууд нь дэргэдээ ази, европ, монгол үндэсний хоолоор үйлчлэх тохилог ресторантай.

*Өнөөгийн байдлаар тус аймаг нь нэг ээлжиндээ 500 зочдыг хүлээн авч байрлуулах хүчин чадалтай жуулчны бааз, амралтын газрууд, нийт 700 орчим суудал бүхий хоол ундааны үйлчилгээний газрууд ажиллаж байна.*

### 2.3.2. аяллын замнал

Байгалийн аялал жуулчлал бол Увс аймгийн аялал жуулчлалын чухал тэргүүлэх чиглэл юм. Дэлхийн байгалийн бүс бүслүүрийн бүхий л шинж төрхийг агуулсан “Увс нуурын их ай сав” хэмээх өргөн уудам нутаг бүхий байгалийн нөөцөөр баялаг, онгон зэрлэг байгал, цэнгэг уст голууд, монголын хамгийн том нуур, зэрлэг амьтадтай “Төв Азийн эко системийн этолон” нутаг төдийгүй олон ястан бүхий нүүдэлчин ардын ахуй амьдрал, зан заншил нь аялал жуулчлал хөгжих үндэс суурь юм.

Өнөөгийн байдлаар аймгийн нутагт дараахи чиглэлийн аяллуудыг санал болгон зохион байгуулж байна.

#### а) Богино хугацаат буюу өдрийн аялал

Аяллын жишээ замнал нь: Улаангом-Увс нуур –Улаангом

Аяллын жишээ замнал нь: Улаангом- Хархираа, Цүнхэгийн амралт- Улаангом

#### б) Дархан цаазат газрын чиглэлд:

Үүнд монголдоо хамгийн том талбайтай Увс нуур, анхны үүслээ хадгалж үлдсэн дэлхийн хамгийн хойд цэгт орших Алтан элс, Тэс, Торхилогийн голын адгийн үзэсгэлэнт орчин, Цагаан шувуут, Цагаан дэглий зэрэг мөнх цаст өндөр уулсын гайхам тогтоцийг ажиглан харж, Хархираа, Онцын тасархай жуулчны баазад амрах, Увс нуурын усанд сэлэх, усны шувуудын цуглааныг үзэх зэргээр 5 – 7 хоногт 1000 орчим км-т аялна. Энд Хархираа, Түргэн, Ямаат, Цагаан шувуут, Атар уулсаар фото аялал зохиож, ирвэсний хаяг үзүүлэх сонирхолтой адал явдлын маршрут ч байж болно.

#### в) Хяргас – Айргийн хоолойн чиглэлд:

Хяргас нуурын дэргэдэх Хар тэрмисийн рашаан сувиллын газар, олон өнгөт элсэн манхануудыг харж, Айргийн хоолойд нүүдлийн аяны гэрт амарч, нүүдэлчин ардын ахуй соёлтой танилцах, загас барих, нуурын усанд сэлэх, шувуудын цуглааныг харах зэргээр 3 – 5 хоногт 500 гаруй км-т аялна. Энд Хяргас нуурын зүүн урд талд орших далайн эргийг санагдуулам байгалийн үзэсгэлэнт “Хэцүү хад”-ыг үзэх маршрут байж болно.

#### г) Говь – Хангайн хослол маршрут

Зүүнговь, Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Малчин, Хяргас сумын нутгаар аялаж, Баян нуур, Өгөөмөр, Алтан бургас, Буштаг, Булганхангай, Баянхайрханы байгалийн онцгой тогтоцтой үзэсгэлэнт газруудыг үзэж Урт булаг, Хүнх, Гивантын рашаан, эртний сүм дуган, овоо тахилгыг сонирхон харах зэргээр 7 – 10 хоногт 2000 – 2500 км-т аялна.

#### д) Уулын спорт- аяллын бүс:

Хархираа, Түргэний уулс, Цагаан шувуут, Цагаан дэглийн мөнх цаст өндөр оргилууд уулчин хүний сэтгэлийг өөрийн эрхгүй татна. 3-5 хоногт 200 – 400 км аялна. Ховдын Гooжуурын хүрхрээ, Дамжиг, Олон нуур, Түргэний Живэрт, Төгс буянтын хүрээ хийдийн туурь, Бөхмөрөний Ямаат зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг үзэж болно.

#### е) Ангийн отгууд бүхий бүс:

Өмнөговь сумын Улиастын шил, Хөх орой, Ховдын Отор, Түргэний Цүнхэг, Шаварт, Сагилийн Цагаан гол, Харгайт, Хан-Хөхийн салбар уулс орчноос буга, тэх,



угалз, бор гөрөөс, гахай зэрэг, ховор нэн ховор амьтныг тусгай зөвшөөрлөөр агнаж болно. Мөн Увс, Хяргас, Айраг, Ачит, Үүрэг, Дөрөө, Баян нуурууд, Ховд, Тэс, Боршоо зэрэг голуудаас загас барьж, шувуу агнах маршрут сонгож болно.

ё) **Усан аяллын бүс:**

Ховд, Тэс, Хархираа, Түргэн зэрэг урсгал сайтай голууд, Увс, Хяргас, Айраг, Дөрөө, Үүрэг, Ачит зэрэг Монголд томоохонд тооцогддог нууруудаар аялах бололцоотой.

ж) **Алдарт хүмүүсийн төрсөн нутгаар:**


Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Увс нутгийн унаган хүү Ю. Цэдэнбалын төрсөн нутгаар аялж, Давст суманд буй түүний музей, Монголдоо ганцханд тооцогддог чулуун давсны орд, Цахирт хад, Увс нуур доторхи хар модон төгөл, тэрчлэн төр, нийгмийн зүтгэлтэн Ж. Батмөнх, Т. Рагчаа, зууны манлай бөх Х. Баянмөнх зэрэг Монголдоо төдийгүй дэлхийд данстай хүмүүсийн өсөж төрсөн газар нутаг, сурч байсан сургууль зэргийг тусгай маршрутаар үзэж сонирхож болно.

Түүх соёлын аяллын замнал жишээ:

- Улаангом – Тэрэм хад – Огзом – Шардал – Цагаан хөшөө - Улаангом /90 км/
- Улаангом – Тэрмэс – Зүүн булаг – Баруун мод – Борнурган – **Бургастай** – Улаангом /320 км/
- Улаангом – Сахлын ам – Далтын ам – Баян мод – Долоон толгой – **Можаа** – Бужаа – Их сар – Бага сар – Нарийн салаа – Бургастай – Улаангом /410 км/
- Улаангом – Бургастайн хуучин бааз – Байрам – Баадайн салаа – Банзараар тойроод Улаангом /450 км/
- Улаангом – Улаан даваа – Бургастайн эх – Байрамын суга – Байрамын хиргэсүүр – Баадайн салаа – Хотгорын уурхай – Ачитын хар элс - Баян-Өлгий /360 км/

Аймгийн нутагт явагдаж буй аяллын чиглэлүүдээс үзэхэд унаган байгаль, нүүдэлчин малчдын амьдралын хэв маяг, түүнтэй уламжлагдан ирсэн түүх соёлын өвд тулгуурлан байгальд түшиглэсэн идэвхитэй, тусгай сонирхолын адал явдалт аяллын төрлүүд түлхүү явагдаж байна.

## ГУРАВ. ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛГО, СТРАТЕГИ



### 3.1. Хөгжлийн хөтөлбөрийн эрхэм зорилго, зорилтууд

#### Эрхэм зорилго

“Дэлхийн өвийн нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар ард иргэд нь байгальтайгаа шүтэлцэн зохицож, зол жаргалтай амьдралыг бий болгоход оршино”

#### Зорилтууд

- Аймгийн аялал жуулчлалын нөөц, өнөөгийн байдалд тулгуурлан аялал жуулчлалын бүсүүдийг ангилан тодорхойлж, бүсүүдийн онцлогт нийцүүлсэн байгаль орчинд эвсэг бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих хэлбэрээр аялал жуулчлалыг орон нутгийн эдийн засагт үр өгөөжтэйгээр хөгжүүлэх
- Аялал жуулчлалын дэд бүтцийг нутгийн иргэд, жуулчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хүрээлэн буй орчинд эвсэг хөгжүүлэх
- Сонирхогч талуудын дэмжлэгтэйгээр иргэдийн ахуй амьдрал, соёл зан заншил уламжлалд нийцүүлэн нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж тэдний амьжиргааг дээшлүүлэх
- Хэрэглэгчийн сэтгэлд нийцсэн чанартай үйлчилгээг хүргэх ур чадвартай боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх

## 3.2. Аймгийн аялал жуулчлалын стратеги төлөвлөлт

### 3.2.1 Зорих газрын төлөвлөлт ба бүсчлэл

Аялал жуулчлалыг хүрээлэн буй орчинд эвсэг тогтвортойгоор хөгжүүлэх үндсэн зорилгын хүрээнд аймгийн нутаг дэвсгэрийг аялал жуулчлалын бүсүүдэд ангилан бүс тус бүрийн онцлогт нийцүүлэн хөгжлийн бодлогыг боловсруулах шаардлагатай байна.

#### Увс аймагт аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх асуудалд

Бүс нутаг бүр газарзүйн байрлал, уур амьсгалын нөхцөл, байгалийн төрх байдал, түүх соёлын дурсгалууд гэхчлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөл нөөцийн хувьд харилцан адилгүй байдаг. Аялал жуулчлалын нөөцүүдийн иж бүрдэл нь тухайн бүс нутгийн аялал жуулчлалын өнгө төрхийг тодорхойлох бөгөөд энэ нь бусад газар нутгаас ялгагдах илүү өвөрмөц, онцгой байж гэмээн аялал жуулчлалыг амжилттай хөгжүүлэх давуу тал олгодог байна.

Иймд **“Бүс нутгийн аялал жуулчлалын төлөвлөлт нь тухайн бүс нутгийн аялал жуулчлалын имижийг тодорхойлоход чиглэгдэх ёстой”** юм.

#### Нөөцийн шинжилгээний арга зүй

Бүс нутгийн аялал жуулчлалын имижийг зөв тодорхойлохын тулд нөөцийн шинжилгээ хийх шаардлагатай болно. Үүний тулд нэн тэргүүнд аялал жуулчлалын боломжит нөөцүүдийн жагсаалтыг бэлтгэх ёстой. Ингэхдээ энэ чиглэлээр урьд өмнө хийгдэж байсан ажлуудтай танилцахаас гадна тухайн бүс нутгийн нөөцүүдийн талаар сайтар мэдэх хүмүүсийг хамруулах нь илүү ач холбогдолтой.

Орон нутгийн аялал жуулчлалын имижийг тодорхойлох зорилгоор жагсаалтаар гаргасан нөөцүүдийг орон нутгийн аялал жуулчлалын имиж, өрсөлдөх чадварын үндсэн үзүүлэлтээр ялгаж, эрэмбийн ялгаварлал гаргана. Үүний тулд голчлон матрицийн аргыг ашигладаг. Энэхүү арга нь оролцооны мониторинг дээр тулгуурласан, бүс нутгийн нөөцүүдийн өрсөлдөх чадварыг тодорхойлоход чиглэгдсэн шинжилгээний арга бөгөөд нөөцүүдийг үнэлэхдээ дараах шалгууруудыг хэрэглэдэг. Үүнд:

1. Бусдаас ялгагдахуйц өвөрмөц шинж чанар
2. Ашиглахад хялбар буюу аялал жуулчлалд татан оруулах боломжтой байдал зэрэг юм.

Үүний дараа гаргасан нөөцийн жагсаалтыг үндэслэн оролцогч бүрийн үнэлгээгээр нөөцүүдийг матрицийн хавтгайд байрлуулж, нэгтгэн, эцсийн дүнг тодорхойлно.


#### Судалгааны үр дүн

Бидний судалгаанд Увс аймгийн 15 байгууллагын төлөөлөл оролцсон бөгөөд Увс аймгийн аялал жуулчлалын нэн тэргүүнд ашиглавал зохих, голлох нөөцүүдэд 38 газрыг нэрлэсэн байна. Оролцогч бүр эдгээр газруудыг бусдаас

ялгарах өвөрмөц байдал ба түүнийг ашиглах боломжоор нь дүгнэснийг нэгтгэж үзвэл дараах байдалтай байна.

№	Газрын нэр	Дундаж оноо	
		Ялгаварлал	Ашиглах боломж
1	Ачит нуур	5.50	5.25
2	Үүрэг нуур	6.00	6.38
3	Цагаан шувуут уул	6.25	7.94
4	Түргэн уул	7.43	7.50
5	Мөнгөт цахир уул	6.63	5.81
6	Давсан уул	7.13	5.75
7	Бор залаан овоо	4.75	3.50
8	Увс нуур	7.81	7.25
9	Холбоо нуур	6.06	4.88
10	Гоожуурын хүрхрээ	8.44	7.31
11	Хяргас нуур	8.63	9.19
12	Баянхайрхан уул	4.19	4.56
13	Гивэнт рашаан	5.50	3.56
14	Нисэх уул	5.43	3.14
15	Хан хөхий	6.44	4.81
16	Хархираа амралт	7.44	6.88
17	Цүнхээгийн амралт	7.29	6.64
18	Алтан элс, Нарийны эх	8.00	6.75
19	Ховд гол	6.00	5.64
20	Ямаат	7.50	8.07
21	Шаазгай нуур	4.50	4.00
22	Ленин толгой	4.17	3.92
23	Заан хад	4.86	4.07
24	Олон нуур	6.14	5.14
25	Буцалдаг	4.67	4.33
26	Урт булгийн рашаан	5.64	5.36
27	Сагил баянзүрх уул	6.31	5.31
28	Боршоон голын хавцал	5.38	5.13
29	Хяргас Айраг нуурын хоолой	7.06	5.63
30	Ногоон цэгээний рашаан	5.08	5.75
31	Сундуйлын рашаан	5.93	4.07
32	Тосон булгийн рашаан	4.75	4.00
33	Шар хяргайн рашаан	6.08	3.67
34	Дөрөө нуур	6.43	6.00
35	Торхилог гол	6.75	6.25
36	Тэсийн гол	6.43	6.50
37	Тариалан халхайн дэнж	7.00	5.71
38	Улаан чандмань уул	7.57	7.29

Жагсаалтаар үйлдсэн 38 газраас ялгаварлалын хувьд дунджаас дээш оноо авсан буюу өөр газар нутагт төдийлөн тохиохгүй, Увс аймгийн аялал жуулчлалын өнгө төрх, имиж болж чадна гэж үзсэн 31 газар нутаг байна. (Эхний багананд улаан болон хөх өнгөтэй тэмдэглэгдсэн)



Эдгээрээс эрчим хүч, зам харилцаа зэрэг дэд бүтцийн хөгжил болон эрхзүйн орчин, хүрээлэн буй орчны асуудал зэрэг үзүүлэлтүүдээр ашиглах боломжийг нь тодорхойлоход 25-ыг нь аялал жуулчлалын өндөр ач холбогдолтой, тэргүүлэх чиглэлийн түшиц газар (хоёрдахь багананд улаан, хөх өнгөтэй), үлдсэн 6-г нь аялал жуулчлалын ач холбогдолтой, төлөвлөлтийн хүрээнд хөгжүүлэх шаардлагатай түшиц газрууд (хоёрдахь багананд ногоон өнгөтэй) хэмээн тодорхойлсон байна.

Аялал жуулчлалын өндөр ач холбогдолтой, тэргүүлэх чиглэлийн түшиц газарт багтсан 25 газраас хамгийн өндөр үнэлгээг Хяргас нуур, Ямаат, Түргэн уул, Гоожуурын хүрхрээ, Увс нуур гэсэн газрууд багтсан байна.

### ***Орон нутагт хийсэн судалгааны урьдчилсан дүгнэлт***

Увс аймгийн аялал жуулчлалын голлох нөөцүүдээр тодорхойлогдсон байгалийн үзэсгэлэнт болон өвөрмөц тогтоцтой газрууд, тусгай хамгаалалттай газрууд, ан агнуурын ач холбогдолтой болон нэн ховор, ховор ан амьтдын бүрдэл бүхий газрууд, түүх соёлын голлох нөөцүүдэд тулгуурласан газар нь хэт нэг дор төвлөрсөн байдал харагдаж байна. Тодруулбал, жагсаалтанд оруулсан 38 газрын 25 нь (65,7%) Хархираа, Түргэний уулс орчимд багахан газар нутагт төвлөрсөн байна.

Аялал жуулчлалын төлөвлөлтийн хувьд үндсэн нөөцүүдэд түшиглэн багахан нутаг дэвсгэрт аялал жуулчлалыг зохион байгуулах нь дараах бэрхшээлүүдийг бий болгож болох юм:

- **Аялал жуулчлалын нөөцийн хэт ачаалал үүсэх.** Тухайн газар нутагт орших нөөцүүдэд өндөр ачаалал үзүүлж, нөөцийн унаган төрх байдал алдагдах, амьдралын хэвийн орчин нөхцөл нь алдагдах, улмаар нутаг орноосоо шилжиж дайжих зэрэг сөрөг үр дагаваруудыг авчирах боломжтой. Энэ нь нэн ховор болон ховор ан амьтад, ургамлын бүрдэл бүхий газруудад хамгийн эрчимтэй нөлөөллийг үзүүлдэг байна.
- **Нөөцийн элэгдэл, эвдрэл нэмэгдэх.** Аялал жуулчлалын эрчимтэй хөгжлийг дагасан зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүчний дэд бүтцийн хэрэглээний өсөлт бий болж, хүрээлэн буй орчны чанарын доройтол, бохирдол газар авах үр дагавар гардаг.
- **Бүс нутгийн хөгжлийн тэнцвэргүй байдал үүсэх.** Тодорхой бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудал нь тухайн бүс нутгийг бүрэн хэмжээгээр хамарч чадахгүй тохиолдолд аялал жуулчлалаас хүртэх үр ашгийн тэнцвэргүй харьцаа үүсч, аялал жуулчлал сул хөгжсөн бүсээс хүмүүсийн шилжилт хөдөлгөөн нэмэгдэх гэх мэтээр хөгжлийн тэнцвэргүй байдал үүсдэг.

#### **Увс аймгийн аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх нь**

Судалгааны ажлын урьдчилсан дүгнэлтээс үндэслээд Увс аймагт аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэхдээ дараах зарчмуудыг баримтлах нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Хүрээлэн буй орчинд аливаа сөрөг нөлөөлөлгүй байх
2. Аялал жуулчлалаас орон нутагт үзүүлэх эдийн засаг, нийгэм, соёлын үр нөлөөлөл нь орон нутагт ижил, хүртээмжтэй байх
3. Аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлт нь бүс нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөлттэй уялдсан байх

Дээрхи зарчмуудын үндэс болгон аялал жуулчлалын нөөцүүдийн ерөнхий төрөл хэлбэрүүд, газарзүйн тархалт байршлын онцлог, хамрах нутаг дэвсгэрийн хэмжээ, түүнчлэн тус аймгийн нутаг дэвсгэрт байрлах улсын болон аймгийн тусгай хамгаалалттай газар нутгуудын байршил, үйл ажиллагааны дэглэм зэргийг харгалзан аялал жуулчлалыг дараах бүсүүдээр хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

1. Ховор амьтдын өлгий нутгийн аялал жуулчлалын бүс
2. Амралт, рашаан сувиллын аялал жуулчлалын бүс
3. Түүх соёлын аялал жуулчлалын бүс
4. Тусгай сонирхлын аялал жуулчлалын эко бүс

**Ховор амьтдын өлгий нутгийн аялал жуулчлалын бүс**

**Тодорхойлолт:** Өндөр уулын мөнх цас, мөсөн гол, түргэн урсгалт голууд, хүрхрээ, нуурууд, нэн ховор ба ховор ан амьтан, ургамал бүхий байгалийн бүс бүслүүрийн олон хэв янз хамгийн бага зайд зэрэгцэн орших “Дэлхийн унаган байгалийн индикатор” бүс

**Хил хязгаар:** Хойд талаараа ОХУ-тай хиллэх улсын хилээр, баруун, баруун урд талаараа Баян-Өлгий аймагтай хиллэх хилээр, зүүн талаараа Хархираа, Түргэний болон Цагаан шувуутын уулсын д.т.д 1500 метрийн өндрийн хаяалбараар (Хархираа, Түргэн, Цагаан шувуутын уулс нь өндөр уулын бүс учраас хээр, ойт хээрийн бүс бүхий дундаж өндөр уулын бүсийн өндөр хаяалбараар тогтоов) хиллэнэ.

**Хөгжүүлэх аялал жуулчлалын чиглэлүүд:** Цагаан шувуут, Түргэн уул, Баянзүрх уул, Гоожуурын хүрхрээ зэрэг нэн ховор ба ховор ургамал, амьтны бүрдэл бүхий ДЦГ-ууд, тэдгээрийн орчим дахь байгалийн үзэсгэлэнтэй болон өвөрмөц тогтоцтой газрууд, монголын болон дэлхийн түүх – соёлын нандин өвүүдэд түшиглэн “Байгаль – түүх соёлын бүх төрлийн аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх.

Энэ бүсийн бүтээгдэхүүний онцлог имидж: **“Нандин, үнэ цэнэтэй, ховор”**

**Аялал жуулчлалын боломжит төрлүүд:**

- Эко аялал (байгалийн үзэсгэлэнт газар, ховор амьтан, ургамал ажиглах)
- Эрдэм шинжилгээний аялал
- Түүх – соёлын аялал (түүх соёлын үнэт дурсгалуудтай танилцах)
- Тусгай сонирхолын аялал (ууланд авирах, морин болон явган, ан агнуур, загасчлах)

**Аялал жуулчлалын хөгжлийн зарчим**

Энэхүү бүсэд хамаарагдах газар нутаг нь байгалийн унаган төрх байдлаа хадгалсан төдийгүй байгалийн экзотик шинж төрхийг агуулсан мөнх цаст өндөр уул, мөсөн гол, түргэн урсгалт голууд, хүрхрээ, нуур, ховор ургамал амьтан бүхий байгалийн бүс бүслүүрийн эрс ялгарлыг үзэх боломж бүхий байгалийн аяллын гол түшиц газар. Гадаад дотоодын жуулчдын хөтөлбөрт байнга хамрагддаг төдийгүй хүмүүсийн үйл ажиллагаанд өртөгдөх, хэт төвлөрөл үүсэх магадлалтай тул эко аялал жуулчлалын шалгууруудыг гол зарчим болгон баримтлана.

- Жуулчдын уг бүсээр нэвтрэн өнгөрөх зам ба хоноглох, амрах газрыг нарийвчлан тогтоож, тэмдэгжүүлэх, жуулчдын тоо болон үйл хөдлөлд хяналт тавих горим боловсруулж, хатуу мөрдөх, гадаад, дотоодын жуулчдад сурталчилан таниулах
- Засгийн газрын 1995 оны 169 дүгээр, тогтоолын 3 дугаар хавсралт. Дархан цаазат болон байгалийн цогцолборт зарим газрын тусгай горимыг мөрдлөг болгох
- Байнгын бус, эко технологи бүхий жуулчны байршуулах хэрэгслийн үйл ажиллагааг дэмжих, цаашид энэ бүсэд ажиллах жуулчны байршуулах хэрэгслийн эко стандартыг боловсруулах

- Хүрээлэн буй орчныг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, тэдгээрийн нөхөрлөл, аялал жуулчлалын байгууллагуудын хамтын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах

### **Амралт, рашаан сувиллын аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс**

**Тодорхойлолт:** Говь хээрийн байгалийн үзэсгэлэнт газар, нуур, элсэн хаялага, рашаан, хадархаг, цохирхог, өндөр хадан хясаа бүхий ургамал амьтны өвөрмөц чуулбар хэсэг бүхий рекрацийн нөөц бүхий бүс.

**Хил хязгаар:** Баруун талаараа бүх төрлийн аялал жуулчлал хөгжүүлэх хилтэй, урд болон зүүн талаараа Ховд, Говь-Алтай, Завхан аймагтай хиллэх хилээр, хойд талаараа Ханхөхийн нурууны ус хагалбараар хиллэнэ.

**Хөгжүүлэх аялал жуулчлалын чиглэлүүд:** Хан хөхийн нуруу, Хяргас, Айраг нуур, Завхан, Хүнгүйн голын адаг тэдгээрийн ландшафтын ялгарал бүхий Ханхөхий-Хяргас нуурын БЦГ-ууд, рашаан амралтын газруудад түшиглэн амралт, рашаан сувиллын аялал жуулчлалыг хөгжүүлэх

### **Аялал жуулчлалын боломжит төрлүүд:**

- Усанд сэлэх, наранд шарах
- Эмчилгээний аялал
- Загасчлах
- Морин болон тэмээн аялал
- Шувуудын цуглааныг ажиглах
- Байгалийн аялал /Ханхөхийн нуруу/

### **Аялал жуулчлалд баримтлах зарчим:**

Энэ бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ орон нутгийн ба иргэдийн тогтвортой хөгжлийг дэмжиж, нөөцийн экологийн тэнцвэрт байдлыг хангах зарчмыг мөрдлөг болгон ажиллана.

- Уг бүсэд зорчих жуулчдын аюулгүй, тав тухтай аялах хангамж, нөхцлийг хангасан чанартай дэд бүтэц, шинэлэг үйлчилгээний байгууламжуудыг төлөвлөж хөгжүүлэх
- Рекрацийн болон бусад нөөцийн ашиглалтын горимыг экологийн даацаас нь хэтрүүлэхгүй байх, дахин ашиглах г.м эко технологи хэрэглэх явдлыг дэмжих, байгалийн нөхцлийн унаган төрх байдлыг хэвээр үлдээхэд орон нутгийн удирдлага, аялал жуулчлалын байгууллагуудын анхаарлыг хандуулах
- Иргэдийн ажил эрхлэлт, мэргэжил боловсролыг дээшлүүлэх замаар аялал жуулчлалын үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийн үр ашигтай оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах
- Бүсийн нутаг дэвсгэр дэх уул уурхайн болон бусад салбарын газар ашиглалтын бодлогыг аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах



### **Түүх соёлын аялал жуулчлалын бүс**

**Тодорхойлолт:** Эртний неолитын үеийн хадны зургуудаас эхлээд янз бүрийн он цагийн хүн чулуу, хөшөө дурсгалыг агуулсан “түүхэн галерей”-н бүс

**Хил хязгаар:** Баруун талаараа бүх төрлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мужийн хилээр, хойд талаараа ОХУ-тай хиллэх хилээр, зүүн талаараа Увс нуурын ДЦГ-ын хилээр, урд талаараа Хан Хөхийн нурууны ус хагалбараар хиллэнэ.

**Хөгжүүлэх аялал жуулчлалын чиглэлүүд:** Аймгийн нутаг дэвсгэрт буй хүн чулуу, буган хөшөө, хадны сүг зураг, хадны бичээс, хиргисүүр, эртний сүм хийдийн туурь зэрэг соёлын нандин өвд тулгуурлан түүх соёлын аялал жуулчлалыг байгалийн аялалтай хослуулан хөгжүүлэх

**Аялал жуулчлалд баримтлах зарчим:** Энэ бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ нөөцийн хадгалалт, хамгаалалтанд орон нутаг, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зарчмыг мөрдлөг болгон ажиллана:

- Улсын болон аймгийн хамгаалалтанд байдаг, түүх соёлын үнэт өвүүдийн орчимд бүс тогтоох замаар хадгалалт хамгаалалтыг нь сайжруулах, орон нутгийн иргэдэд үл хөдлөх дурсгалуудыг гэрээгээр хариуцуулж, урамшууллын тогтолцоо бий болгох
- Хилийн болон ТХГН-ын хүрээнд хамаарах дурсгалуудыг аялал жуулчлалын үр ашигтай эргэлтэнд оруулах асуудлыг дэмжиж, харилцан ашигтай байдлаар шийдвэрлэх
- Түүх соёлын дурсгалт газруудын талаархи судалгаа шинжилгээний ажлыг дэмжиж, орон нутгийн иргэд болон жуулчдыг мэдээллээр хангах, түүхэн үнэт чанарыг нь сурталчилах

### **Тусгай сонирхлын аялал жуулчлалын эко бүс**

**Тодорхойлолт:** Дэлхийн өвийн сүлжээнд сүлжээнд бүртгэгдсэн Увс нуурын ай савын бүс Монголын хамгийн том нуур, дэлхийн хамгийн хойд захын элс, баян бүрд бүхий эко бүс.

**Хил хязгаар:** Баруун талаараа түүх соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх мужийн хилээр, хойд талаараа ОХУ-тай хиллэх хилээр, урд талаараа Хан Хөхийн нурууны ус хагалбараар хиллэнэ.

**Аялал жуулчлалд баримтлах зарчим:** Энэ бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ нөөцийн унаган төрх байдлыг хэвээр хадгалан үлдээж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зарчмыг баримтална:

- Увс нуурын усанд сэлэх болон шувуу ажиглах цэгүүдийг тогтоож, тэмдэгжүүлэх, тохижуулах, жуулчдын аюулгүй байдлыг нь хангах болон эрэг орчмын байгалийн унаган төрхийг нь хэвээр хадгалж үлдэхэд анхаарч ажиллах
- Уг бүс нутаг дахь сэтгэл татах үзмэрүүдийн нарийвчилсан судалгаа хийж, гадаад, дотоодын жуулчдад сурталчилах, тэдгээрийн дагуух аялал

- жуулчлалын дэд бүтцийг орон нутгийн хөгжилд ашигтай хэлбэрээр зохион байгуулах
- Орон нутгийн иргэдийн уламжлалт ахуй, соёлын үнэт зүйлсэд тулгуурласан **эвент** арга хэмжээг хамтран зохион байгуулах

### 3.2.2 Бүтээгдэхүүн үйлчилгээний стратеги

Увс аймаг нь жуулчдын сонирхолыг татах боломж харьцангуй өндөр төдийгүй цаашдаа ч нэмэгдэх хандлагатай байна. Зорих газрын төлөвлөлт бүсчлэлийн хүрээнд жуулчид зорилтот зах зээлээс авах бүтээгдэхүүн, үйлчилгээний багцуудыг санал болгох тул төрөл бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетингийг нэгтгэх нь зүйтэй.

Аймгийн нутагт аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэхийн тулд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгохоос гадна одоо байгаа бүтээгдэхүүний нэгж үйлчилгээ тус бүрийг нарийвчлан тодорхойлох, чанарыг сайжруулан хөгжүүлэх явдал юм.

Аймгийн хувьд үйлчилгээг дараах байдлаар бүрдүүлж байна.

- Аймгийн нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны бааз
- Амралт, сувиллын газар /хавсралтаас үзнэ үү/
- Хоол ундааны болон бусад үйлчилгээний газрууд /зоогийн газар, кафе, үсчин г.м/
- Нутгийн иргэд малчдын бүлэг, нөхөрлөлүүд /морь, тэмээ, гэр буудал, газарчин, бэлэг дурсгал /
- Гар урлалын бүтээгдэхүүн

### Бүтээгдэхүүний стратеги

Увс аймгийн аялал жуулчлалын бүсүүдэд болон УНАС-ын улсын тусгай хамгаалалттай газарт гадаад дотоодын аялагчдын зорин ирэх зах зээлийн урсгалыг тодорхой чиглэлээр тусгайлан төрөлжүүлэх, санал болгож буй багц бүтээгдэхүүн үйлчилгээг хангагчдыг мэргэшүүлэх, давтан сургах, цаашлаад ганцаарчилсан болон зохион байгуулалттай бүлэг жуулчдад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох ч боломжтой.

Тухайлбал судалгаанаас үзэхэд ховор амьтдын өлгий нутгийн бүсэд аялал жуулчлалын суурь нөөцүүд төвлөрсөн байгаа нь цаашдаа тухайн бүсэд өндөр ачаалал үзүүлж, нөөцийн унаган төрх байдал, амьтдын амьдралын хэвийн орчин нөхцөл нь алдагдах, улмаар нутаг орноосоо шилжиж дайжих зэрэг сөрөг үр дагаваруудыг учруулж болзошгүй. Энэ нь нэн ховор болон ховор ан амьтан, ургамлын бүрдэл бүхий газруудад хамгийн их сөрөг нөлөөллийг үзүүлдэг. Цаашдаа сууршмал цементэн суурьтай жуулчны бааз барихыг хориглох ба байнгын бус, эко технологи бүхий жуулчны байршуулах хэрэгслийн үйл ажиллагааг дэмжих хэрэгтэй.

Аймгийн нутагт аялагч жуулчдад санал болгох нэгж бүтээгдэхүүн үйлчилгээ бүрийн хувьд бүсүүдийн онцлогтой уялдуудан зарчим, стратегийг ялгаатайгаар хөгжүүлэх шаардлагатай байна.

**Ховор амьтдын өлгий нутгийн аялал жуулчлалын бүсэд бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх стратеги:**

Өндөр уулын мөнх цас, мөсөн гол, түргэн урсгалт голууд, хүрхрээ, нуурууд, нэн ховор ба ховор ан амьтан, ургамал бүхий байгалийн бүс бүслүүрийн олон хэв янз хамгийн бага зайд зэрэгцэн орших “Дэлхийн унаган байгалийн индикатор” бүс. Энэ бүсэд Монгол улсын тусгай хамгаалалттай буюу дархан цаазат газрын хууль, дүрэм журмуудыг баримтлан ажиллана.

а/ Шинээр байгуулах жуулчны баазад эко стандартыг хангасан байнгын бус жуулчны баазыг дэмжих

б/ Хүрээлэн буй орчинд эвсэг хэлбэрээр шинэлэг технологийг нэвтрүүлэн, тогтвортой хөгжлийн зарчмын шалгуурыг ханган ажиллах тохиолдолд л цөөн тооны жуулчны баазад хамгаалалтын захиргаа, нутгийн иргэд, аялал жуулчлалын зөвлөлийн дүгнэлтээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгодог байх

в/ Жуулчны уг бүсээр нэвтрэн өнгөрөх ба хоноглох, амрах газрыг нарийвчлан тогтоож тэмдэгжүүлэх

г/ Жуулчдын тоо болон үйл хөдлөлд хяналт тавих горим боловсруулж хатуу мөрдөх

д/ Бүтээгдэхүүн, үйлчилгээг стандартжуулах

е/ Гадаад дотоодын жуулчдад сурталчлан таниулах

ё/ Засгийн газрын 1995 оны 169 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт. Дархан цаазат болон байгалийн цогцолборт зарим газрын тусгай горимыг мөрдлөг болгох

ж/ Үзмэрийн баяжилт ба чанарыг сайжруулах

з/ Хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, тэдгээрийн нөхөрлөл, аялал жуулчлалын байгууллагуудын хамтын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах

и/ Жуулчны бааз, нутгийн иргэд малчдын нөхөрлөлтэй хамтран хог хаягдлын менежментийг бий болгох

й/ Аялал зохион байгуулж буй байгууллагуудтай хамгаалалтын захиргаа, сумын захиргаа, малчдын нөхөрлөлүүд гэрээ байгуулах замаар орлогын тодорхой хувийг сумын аялал жуулчлалын санд төвлөрүүлдэг болгох төдийгүй иргэдийн оролцоог идэвхижүүлэн аялал жуулчлалаас тодорхой орлого олох боломж олгох

▪ ***Амралт, рашаан сувиллын аялал жуулчлалын бүсэд бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх стратеги:***

Говь хээрийн байгалийн үзэсгэлэнт газар, нуур, элсэн хаялага, рашаан, хадархаг, цохио, өндөр хадан хясаа бүхий ургамал амьтны өвөрмөц чуулбар хэсэг бүхий рекреацийн нөөц бүхий бүс. Хяргас нуурын дэргэдэх Хар тэрмисийн рашаан нь дотоодын аялагчид /Увс, Ховд аймгийн/ олноор зорин ирж амардаг газар. Энэ бүсэд зорин ирэх дотоод гадаадын жуулчдын тоо жил ирэх бүр өсөн нэмэгдэж байгаа нь нэг талаас энэ зах зээлийн эрэлтийг хангах, нөгөө талаас газар нутаг, нөөцийн даац, хүчин чадалд нийцүүлэн амралт, эмчилгээ сувиллын аялал жуулчлалыг төлөвлөх шаардлагатай. Орчны газар нутагт байгаль орчны үнэлгээ хийлгэх, хамгаалах, зүй зохистой хэрэглээг бий болгох, нөөцийн экологийн тэнцвэрт байдлын хангах зарчмыг баримтлах шаардлагатай. Монгол улсын тусгай хамгаалалттай буюу байгалийн цогцолборт газрын хууль, дүрэм журмуудыг баримтлан ажиллана.

- а/ Тус бүсэд зорчих жуулчдын аюулгүй, тав тухтай аялах боломж, нөхцлийг хангасан чанартай дэд бүтэц, шинэлэг үйлчилгээний байгууламжуудыг төлөвлөж хөгжүүлэх
- б/ Рекреацийн болон бусад нөөцийн ашиглалтын горимыг экологийн даацаас нь хэтрүүлэхгүй байх, дахин ашиглах г.м эко технологи хэрэглэх явдлыг дэмжих, байгалийн нөхцлийн унаган төрх байдлыг хэвээр үлдээхэд орон нутгийн удирдлага, аялал жуулчлалын байгууллагуудын анхаарлыг хандуулах
- в/ Иргэдийн ажил эрхлэлт, мэргэжил боловсролыг дээшлүүлэх замаар аялал жуулчлалын үйл ажиллагаанд орон нутгийн иргэдийн үр ашигтай оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах
- г/ Бүсийн нутаг дэвсгэр дэх уул уурхайн болон бусад салбарын газар ашиглалтын бодлогыг аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлттэй уялдуулах

▪ **Түүх соёлын аялал жуулчлалын бүсэд бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх стратеги:**

Эртний неолитын үеийн хадны зургуудаас эхлээд янз бүрийн он цагийн хүн чулуу, хөшөө дурсгалыг агуулсан “түүхэн галерей”-н бүс.

Аймгийн нутаг дэвсгэрт эртний түүх соёл, дурсгалт зүйл болох хүн чулуу 104, буган хөшөө 21, хадны сүг зураг 90 гаруй цэгт 40.000 гаруй, бичиг тэмдэгт хөшөө 20, гэрэлт хөшөө 1, хадны бичээс 10, түүнчлэн олон мянган хиргисүүр, цөөнгүй тооны эртний сүм хийдийн үлдэгдэл, балгас бүртгэгдэж тэмдэглэгдсэн. Эдгээрээс Чандмань уулын археологийн олдвор нь эртний түүх соёлын нандин өвд тооцогддог. Сүүлийн үед дээрх түүх соёлын дурсгалууд байгалийн болон гадны нөлөөллөөс эвдэрч гэмтэх, хуучин хэв байдлаа алдах явдал гарч байна. Энэ бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ нөөцийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зарчмыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

а/ Улсын болон аймгийн хамгаалалтанд байдаг, түүх соёлын үнэт өвүүдийн орчимд хамгаалалтын бүс тогтоох замаар хадгалалт хамгаалалтыг нь сайжруулах, орон нутгийн иргэдэд үл хөдлөх дурсгалуудыг гэрээгээр хариуцуулах, урамшууллын тогтолцоо бий болгох

б/ Хилийн болон ТХГН-ын хүрээнд хамаарах дурсгалуудыг аялал жуулчлалын үр ашигтай эргэлтэнд оруулах асуудлыг дэмжиж, харилцан ашигтай байдлаар шийдвэрлэх

в/ Түүх соёлын дурсгалт газруудын талаархи судалгаа шинжилгээний ажлыг дэмжиж, орон нутгийн иргэд болон жуулчдыг мэдээллээр хангах, түүхэн үнэт чанарыг нь сурталчилах

▪ **Тусгай сонирхлын аялал жуулчлалын эко бүсэд бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх стратеги:**

Дэлхийн өвийн сүлжээнд бүртгэгдсэн Увс нуурын ай савын бүс Монголын хамгийн том нуур, дэлхийн хамгийн хойд захын элс, баян бүрд бүхий эко бүс. Увс нуурын ай савын газрыг 1993/1995 онд ДЦГ болгосон. 1997 онд НҮБ-ын олон улсын шим мандлын нөөц газрын сүлжээнд, 2003 онд дэлхийн өвийн сүлжээнд бүртгэгдсэн. Эко аяллын бүс нь аймгийн төдийгүй Монгол улсын хувьд асар их үнэ цэнэтэй төдийгүй маш эмзэг байгальтай тул энэ бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ нөөцийн унаган төрх байдлыг хэвээр хадгалан үлдээж, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зарчмыг баримтална.

Увс нуурт богино хугацаатай /өдрийн/ амрагчид зуны улиралд ихээхэн ирдэг. Хүмүүсийн үйл ажиллагаанд багавтар өртөгдсөн ч хог хаягдал нэмэгдэх болсон. Монгол улсын тусгай хамгааллалттай буюу байгалийн цогцолборт газрын хууль дүрэм журмуудыг баримтлан ажиллана.

а/ Увс нуурын усанд сэлэх болон шувуу ажиглах цэгүүдийг тогтоож, тэмдэгжүүлэх, тохижуулах, жуулчдын аюулгүй байдлыг нь хангах болон эрэг орчмын байгалийн унаган төрхийг нь хэвээр хадгалж үлдэхэд анхаарч ажиллах

б/ Уг бүс нутаг дахь сэтгэл татах үзмэрүүдийн нарийвчилсан судалгаа хийж, гадаад, дотоодын жуулчдад сурталчилах, тэдгээрийн дагуух аялал жуулчлалын дэд бүтцийг орон нутгийн хөгжилд ашигтай хэлбэрээр зохион байгуулах

в/ Орон нутгийн иргэдийн уламжлалт ахуй, соёлын үнэт зүйлсэд тулгуурласан **эвент** арга хэмжээг хамтран зохион байгуулах

г/ Эко бүсэд үйл ажиллагаа явуулахад оролцож буй талуудын саналыг харгалзан, эрх үүргийг нарийн тогтоох

### **Санал болгож буй аяллын төрлүүд**

Аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн онцлог, суурь нөөцөд тулгуурлан цаашид дэмжин хөгжүүлэх аяллын төрлүүдийг тодорхойлж байна.

**Байгалийн аялал:** Дэлхийн өвд бүртгэгдсэн байгалийн үзэсгэлэнт нутаг харьцангуй богино зайнд байгалийн бүс бүслүүрийн бүхий л шинжийг харах, олон ястны нүүдэлчин малчдын ахуй амьдрал, түүх соёлтой танилцах аяллыг зохион байгуулах боломжтой

**Явган/морин аялал:** Жуулчид өөрийн хүссэнээр аялаж болох хамгийн тохиромжтой хэлбэр бөгөөд явган аялалд оролцогчдын тоо сүүлийн жилүүдэд өсөж байна. Морин аялал нь гадаад, дотоодын жуулчдын ихээхэн сонирхдог аялал жуулчлалын нэг төрөл юм. Байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалтай танилцахад жуулчдад өргөн боломж олгодог төдийгүй хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай. Хархираа, Түргэний уулсын /Түргэний дархан цаазат газар/ нутагт болон тусгай сонирхлын аялал жуулчлалын эко бүс дэхь Баян нуур, Бөөрөг дэлийн элсний чиглэлд явган ба морин аяллыг тодорхой зам маршрутын дагуу нутгийн иргэд, малчдын нөхөрлөлд түшиглэн зохион байгуулах боломжтой. Хархираа, Түргэний уулс орчмын газар нутаг нь явган аяллын хувьд хамгийн тохиромжтой байгалийн иж бүрдэл бүрдсэн экзотик шинжтэй.

**Нэн ховор амьтан түүний ул мөрөөр аялах аялал:** Хархираа, Түргэний уул, Ямаат уул, Цагаан шувуут уулын нутгаар Зэрлэг байгалийн “хатан хаан” ирвэсийн хаяг, бумбаа, мод самардсан зэрэг ул мөрөөр аялах төдийгүй аргаль, янгирыг ажиглан харах боломжтой.

**Түүх соёлын аялал:** Сагилын Можоо, Бужаагийн хадны зураг, Зүүнхангайн Зураагийн хадны зосон зураг зэрэг төдийгүй дэлхийд хоёрхон байдаг эртний түүх соёлын дурсгалтай танилцах аяллыг зохион байгуулах. Түүх соёлын аяллыг Сагил, Давст сумын чиглэлд илүүтэй хөгжүүлэх боломжтой.

**Шувуу ажиглах аялал:** Увс, Хяргас нуур, Хяргас Айргын хоолой, Үүрэг нуур зэрэгт усны шувуудын цуглааныг ажиглах аяллыг 5-6 саруудад зохион байгуулах боломжтой.

**Ан агнуурын аялал:** Өмнөговь сумын Улиастын шил, Хөх орой, Ховдын Отор, Түргэний Шаварт, Сагил сумын Цагаан гол, Харгайт, Ханхөхий салбар уулс орчмоос буга, тэх, угалз, бор гөрөөс, гахай, зэрэг нэн ховор амьтныг тусгай

зөвшөөрлөөр агнаж болно. Хяргас, Айраг, Ачит, Үүрэг, Дөрөө зэрэг нуураас загас барих боломжтой.

**Уулын аялал:** Хархираа Түргэний уулс, Цагаан шувуут, Цагаан Дэглийн мөнх цаст өндөр оргилуудад авирах. Түүнчлэн Гоожуурын хүрхрээ, Дамжиг, Олон нуур, Түргэний Живэрт, Ямаат зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудыг харах боломжтой.

**Нүүдэлчдийн амьдралтай танилцах болон угсаатны аялал:** Баяд, дөрвөд, халх, хотон ястан малчин айлд зочлон нүүдэлчин ахуйтай танилцах, соёл зан заншил, нутгийн зан үйлд суралцах зэрэг сонирхолтой идэвхитэй аяллыг нутгийн иргэд, малчдын нөхөрлөлд түшиглэн зохион байгуулах боломжтой.

Санал болгож буй эдгээр аяллыг дагнасан хэлбэрээр хөгжүүлэхээс гадна хосолсон байдлаар хэрэгжүүлэх нь ач холбогдолтой юм. Мөн сумын наадам, даншиг, овоо тахилга, бэсрэг наадам зэрэг орон нутгийн тэмдэглэлт үйл явдлуудтай холбосон аяллын хөтөлбөр, тухайн бүсийн онцлогт тулгуурласан төрөл бүрийн эвент арга хэмжээг зохион байгуулах нь илүү үр дүнтэй.

Морь, тэмээ хөлслөхөөс гадна орон нутгийн онцлогыг харуулсан гар урлалын бүтээгдэхүүн бэлэг дурсгалын зүйлсийг үйлдвэрлэхэд нутгийн иргэдийг татан оролцуулж тэдний орлогыг нэмэгдүүлэх явдал юм. Сонирхогч талуудын дэмжлэгтэйгээр иргэд, малчдын нөхөрлөлд сургалт зохион байгуулан эсгий урлал, нэхмэл, хатгамал, сийлбэр хийх, үндэсний хувцас дээл, малгай, хантааз оёх зэрэг өрхийн болон жижиг үйлдвэрлэлийг дэмжих боломж байна.

### 3.2.3 Маркетингийн төлөвлөлт

Аялал жуулчлал нь бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож, борлуулах үйл ажиллагаа явуулж байдгаараа үйлдвэрлэлийн шинжтэй. Байгууллага бүрт аялал жуулчлалын улиралд ирэх жуулчдын тоо, бүтцийг тогтоох, зах зээлийн сегментийг сонгох, хэрэглэгчдийн эрэлтийг тодорхойлох, үйлчилгээний чанарыг урьдчилан тогтоох зэрэг шаардлага урган гардаг.

Увс аймгийн өнөөгийн нөхцөл байдал, аялал жуулчлалын бүсүүдийн онцлог, нөөц боломжууд, хөгжүүлэхийг зорьж буй бүтээгдэхүүн үйлчилгээний онцлогуудтай уялдан зорилтот зах зээлийг дараах байдлаар хэсэгчлэн тэдгээрийн онцлогт тулгуурлан маркетингийн ялгаварт стратегиудыг баримтлана.

Аймгийн хувьд одооноос “Хүрээлэн буй орчинд ээлтэй” –гээр аялал жуулчлалыг хөгжүүлэх нь аялал жуулчлалын хөгжлийн алсыг харсан загвар стратеги болж байна.

Зорилтот зах зээлийн хэсгүүд		Аяллын төрөл	Маркетингийн стратеги
Дотоодын жуулчид	өсвөр насныхан	Танин мэдэхүйн, спорт, адал явдал	Мэдээлэл түгээх, танилцуулах, зохицуулалт, хүрэх үр дүн: Эх орноороо бахархах бахархалыг төлөвшүүлэх
	Дунд насныхан	Түүхийн, байгалийн, амралт АЖ	Мэдээлэл түгээх, журам болон үйлчилгээг сайжруулан татах, хүрэх үр дүн: байгалийн үзэсгэлэнт газар амрах, алжаалаа тайлах, түүх соёлын танин мэдэх
	өндөр насныхан	Шашин шүтлэг, эмчилгээ, сувилал	Мэдээлэл түгээх, журам болон үйлчилгээг сайжруулах, зохицуулалт хийх хүрэх үр дүн: Тусгай маршрутаар аялах, эмгүй эмчилгээний зорилгыг хэрэгжүүлэх
Гадаадын жуулчид	Бие даан үүргэвчтэй аялагчид	Байгалийн аялал жуулчлал, адал явдал	Мэдээллийг түгээх, танилцуулах, эко гэрийн үйлчилгээ, веб сайт ажиллуулах
	Багц аяллын жуулчид/тур операторуудаар үйлчлүүлэгчид/	Байгалийн, тусгай сонирхолын...г.м	Танилцуулах, мэдээлэл түгээх, танилцах аялалд оролцуулах

*Хүснэгт: Аймгийн аялал жуулчлалын маркетингийн стратеги*

***Зорилтот зах зээлийн хэсэг дотоодын жуулчид***

Дотоодын аялагчид өөрийн орны үзэсгэлэнт байгаль, түүх соёлын дурсгалт газруудтай танилцах, амарч зугаалах зэрэг төрөл бүрийн аялалд оролцох хүсэл сонирхолтой байдаг. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд дотоод зах зээл рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай. Цаашдаа дотоодын аялагчдад зориулсан нэгдсэн арга хэмжээг зохион явуулах нь илүү үр дүнтэй.

Увс, Хяргас нуур, Урт булагийн рашаан, Хархираа, Цүнхэгийн амралт зэрэг нь дотоодын аялагчдын гол түшиц газар юм. Увс нуур, Хяргас нуур, Хархираагийн амралт нь аймгийн төдийгүй Ховд аймгийн аялагч амрагчид зуны улиралд олноор зорин ирдэг газар юм.

Увс нуур нь дэлхийн өвд бүртгэгдсэн, улсын тусгай хамгаалалтанд авсан дархан цаазтай монголын хамгийн том нуур. Увс нуурт усанд сэлэх тогтоосон цэгт өдрийн амрагчид ихээр очиж амардаг. Хүмүүсийн үйл ажиллагаанд багавтар өртөгдсөн ч хог хаягдал нэмэгдэх болсон байна.

Хяргас нуур Хар Тэрмисийн амралт рашаанд зуны улиралд амрагчид олноор ирдэг төдийгүй хувиараа гэр бүлээрээ ирж амрагчдын тоо нэмэгдсээр байна.

Иймд Баруун бүс болон Улаанбаатар, хөдөө орон нутаг дахь дотоодын аялагчдад зөв амралтын талаар мэдээлэл түгээх, сурталчлах, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах нь дотоодын аялагчдын тогтвортой үйл ажиллагаанд чухал нөлөөтэй байна. Цаашдаа Хар Тэрмисийн рашаан сувиллын газрын ажиллах хоногийн тоог нэмэгдүүлж, материаллаг нөхцөл, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Увс нуурын усанд сэлэх, наранд шарах орчныг тохижуулах, нүүдлийн боловсон WC байгуулах боломжийг судлах хэрэгжүүлэх, Улаангом сум-Увс нуурын хооронд зуны улиралд 7 хоногт 3 удаа амрагчдыг тээвэрлэх /нийтийн тээвэр/ талаар ААН, амралт сувиллын газруудтай хамтран хэрэгжүүлэх шаардлагатай.

***Зорилтот зах зээлийн хэсэг гадаадын жуулчид***

Бие даан үүргэвчтэй аялагчид тур операторуудын санал болгосон үйлчилгээнд хамрагдалгүй ямар нэг хатуу төлөвлөсөн аяллын хөтөлбөргүйгээр аялалд оролцдог. Сүүлийн жилүүдэд энэ төрлийн жуулчдын тоо улам бүр өсөн нэмэгдэж байна. Үүргэвчтэй аялагчид ганцаараа болон хэсэг бүлгээрээ нийлж мэдээллийн төвөөр үйлчлүүлэн аялах чиглэл, маршрутаа сонгоод автомашин түрээслэн авч аялдаг байна.

Үүргэвчтэй аялагчдыг татахын тулд жуулчны мэдээллийн төв болон эко гэрт Улаанбаатар хотын ирэх очих нислэгийн хуваарь, аймаг орон нутаг дахь байрлуулах болон хоол ундааны үйлчилгээний газруудын байршил, үйлчилгээний онцлог, холбоо барих утас, хаяг, ТХГН-ын дэглэм, хоноглох, отоглох газрын байрлал, хаанаас морь, тэмээ, машин хөлслөн авч болох, нүүдэлчин айл малчдын нөхөрлөлийн байршил, үйлчилгээний төрөл үнийн санал, аялал жуулчлалын бүсүүдэд аялахад баримтлах зарчим зэрэг мэдээллийг түгээх шаардлагатай. Эко гэр, жуулчны бааз, малчдын нөхөрлөлүүдээр дамжуулан судалгаа санал авч цаашид ямар төрлийн мэдээлэл үйлчилгээ хэрэгтэйг тодорхойлон үйл ажиллагаандаа тусгах нь чухал. Аймгийн вэб хуудас, мэдээллийн төв, товхимол, тараах материал зэрэг мэдээллийн сувгийг ашиглах боломжтой. Аймгийн жуулчны



мэдээллийн төвийг Улаанбаатар хот дахь аялал жуулчлалын мэдээллийн “Гийчин” төвийн үйл ажиллагаатай уялдуулах.

Тур оператороор үйлчлүүлж Монгол улсад ирж буй жуулчдын дийлэнхи хувийг багц аяллын жуулчид эзлэдэг нь судалгаагаар тогтоогдсон. Тус аймагт өнгөрсөн жилүүдэд Япон, Германчууд эзлэж байсан бол энэ жил Америк, Англи, Орос жуулчид дийлэнхи хувийг эзэлж байна. Ирж буй жуулчдын ихэнхи хувь буюу 70-80% нь байгалийн аялал жуулчлал экотуризмыг сонирхдог. Европоос ирж буй жуулчдын дийлэнх нь байгалийн сайханд амрах, аялах, явган аялах, тусгай сонирхолын аялал болох уулын аялагч, спорт аялагч, анчин жуулчин, шувуу сонирхогч зэрэг аяллуудыг сонирхон ирж байхад Азийн жуулчид тэр дундаа Япончууд чулуун давс орд, Шүдэн уулыг үзэх, чацаргана тарих, арга технологитой танилцах, цаашид хамтран ажиллах зорилготой ирж байсан нь судалгаагаар тогтоогдсон. Иймд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах тур операторуудтай нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, нутгийн иргэдэд түшиглэсэн хэлбэрээр зохион байгуулах стратегийг баримтлах нь зүйтэй юм.

Дэлхийн өв болсон байгалийн үзэсгэлэн бүхий, ховор нэн ховор амьтдын өлгий нутгаар идэвхитэй эко аяллыг нутгийн иргэдэд түшиглэн тур операторуудын хамтын дэмжлэгтэйгээр бий болгож, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх стратеги барьж ажиллах боломжтой.

Цаашдаа улсын чанартай үзэсгэлэн яармаг, уулзалт ярилцлагад тогтмол оролцон аяллын тухай мэдээлэл өгч ажиллах арга нь үр дүнтэй юм.

Жуулчны үйлчилгээг сайжруулах, орон нутгийн иргэдийг идэвхижүүлж чадавхижуулахад тур операторууд, аялал жуулчлалын төрийн бус байгууллага, гадаадын төсөл хөтөлбөрүүд, сонирхогч талуудын дэмжлэгтэйгээр орон нутаг дахь жуулчны үйлчилгээг хүргэгчдийг бэлтгэх, сургах, чадваржуулах улмаар үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай.

Увс аймгийн хувьд аялал жуулчлалын маркетингийн үйл ажиллагаа нь *дотоодын жуулчдад*: хүрээлэн буй орчинд эерэг, зохион байгуулалттай амралт идэвхитэй аяллыг таниулахад чиглэгдэх бол *Гадаадын жуулчдад*: Увс аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийн талаарх мэдээлэл түгээх, аялал жуулчлалын бүсийн ялгавартай бодлого баримтлах, сурталчилахад чиглэгдэнэ.

### **Маркетингийн стратеги:**

Аялал жуулчлалын зорих газрууд нь өөрчлөгдөн байгаа эрэлт хэрэгцээ, шаардлагуудыг соргоогоор мэдэрч маркетингийн үйл ажиллагаагаа шинэчилэж байх хэрэгтэй байдаг. Аялалын явц, бүтээгдэхүүн, үйлчилгээний багцуудыг санал, болгох зэрэг нь хэдийгээр салангид үйл ажиллагаа мэт боловч бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетингийг цогц байдлаар хэрэгжүүлэх хэрэгтэй болдог.

Увс аймгийн аялал жуулчлалын бүсүүд өөр өөрийн гэсэн онцлогт тулгуурласан ялгавартай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох нь зүйтэй.

Стратеги:

- Бусад бүс нутгуудаас ялгарах имиджийг тодорхойлох
- АЖ-ын бүтээгдэхүүн шинээр гаргах, үйлдвэрлэх
- Бүсийн онцлогт нийцүүлэн янз бүрийн эвентүүдийг зохион байгуулах
- Мэдээллээр хангах, түгээх
- АЖ-ын үйл ажиллагаа эрхлэгчидтэй хамтарсан маркетингийн идэвхижүүлэлт хийх

- Нэг жуулчинаас олох ашиг орлогыг нэмэгдүүлэх /үнийг нэмэх бус бүтээгдэхүүний төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх замаар ашиг орлогыг өсгөх/
- Хууль эрх зүйн орчныг сайжруулах
- Байгаль хамгаалал:
  - Байгаль орчны хувьд эмзэг, ховордсон зүйлийг тодорхойлж газрын зурагт байрлуулах
  - Аялал жуулчлалд зориулж байгаль орчны хөтөлбөр гаргах
  - Мэдээллийн самбар, хог хаягдалын менежментийг бий болгох
  - АЖ-ын үйл ажиллагаа явуулж буй компани, хувь хүн, сонирхогч талуудад мэдээлэл түгээх
  - Байгаль орчинд ээлтэй бизнесийг сертификатжуулах жнь нь: Ногоон hotel г.м.
  - Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа компани, хувь хүн, сонирхогч талуудад байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх
  - Байгаль хамгаалах ерөнхий компани үйл ажиллагааг өргөжүүлэх /жнь: байгаль орчныг хамгаалах талаар календарь гаргах, байгаль орчныг хамгаалах жижиг төсөл боловсруулах/
  - Бусад үйл ажиллагаа
- Судалгаа:
  - Байгалийн нөөцийн суурь судалгаа
  - Эдийн засгийн тоо баримт
  - Зах зээлийн судалгаа хийж дүгнэлт санал боловсруулах
  - Мэдээллийн сан байгуулах
  - Мэдээллээ түгээх

Чанартай үйлчилгээ үзүүлж, стандартыг мөрдөх замаар дэлхийн жишигт нийцсэн үйлчилгээг бий болгох

Стратеги:

- Жуулчны аюулгүй байдал, даатгал гэх мэт
- Ур чадварыг нэмэгдүүлэх
- Үйлчилгээний чанар
- Хувь хүний хандлага
- Цэвэр орчин
- Харилцаа холбоо авч чадах байдал /интернет, гар утас г.м/
- Жуулчин юу хүсэж байгааг мэдэх
- Чанартай бүтээгдэхүүн санал болгох

Тогтвортой байдал:

Ирээдүйд тогтвортой хөгжүүлэх, хэрэглэхийн тулд нөөцөө хамгаалах, хадгалах, тогтвортой амьжиргааг дэмжих

Стратеги:

- Бүс нутгийн хэмжээний аялал жуулчлалын дагаж мөрдөх зөвлөмж журам боловсруулах
- Ховор ан амьтдын өлгий нутгийн бүсэд дагаж мөрдөх аялал жуулчлалын эко стандартыг боловсруулах
- Жуулчдын хувьд ёс зүйтэй байх /хариуцлагатай/ нөхцлийг бүрдүүлэх
- НИТАЖ-ыг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, амьжиргааны эх сурвалжыг бий болгох /туслах аж ахуй, гар урлал бэлэг дурсгал г.м./

- Иргэдийн боловсрол /Аялал жуулчлал, байгаль экологи, соёлын өвийн үнэ цэнэ/
- Төрийн болон хувийн олон нийтийн байгууллага, ард иргэдийн үүрэг роль олон нийтийн оролцоо

Аймгийн аялал жуулчлалын бүсүүдийн онцлогт нийцүүлэн бусдаас ялгагдах бүтээгдэхүүнийг зах зээлд санал болгохдоо дараах стратегийг баримтална.

*Аялал жуулчлалын бүтээгдэхүүн гаргах үйл ажиллагаа:*

- Зах зээлийн судалгаа хийх /гадаад, дотоод/
- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа
- Бүтээгдэхүүнийхээ талаар мэдээлэл түгээх сурталчлах:
  - Уриа, лого имидж бүрдүүлэх
  - Танилцуулга, брошур гаргах
  - үзэсгэлэн яармагт оролцох
- Сувинер бий болгох /орон нутгийн онцлог төрхийг илэрхийлсэн тухайлбал: модон бал, балны тавиурыг давсаар хийх, ирвэсийн зураг бүхий эсгий, ирвэсийн зурагтай цамц, богино өмд, малгай хийх, эсгий шаахай, гэр, ан амьтдын дүрсийг давсаар урлах г.м /

Аймгийн жуулчны мэдээллийн төвийг байгуулах нь :

- Аймгийн АЖ-ын үйл ажиллагааг сурталчлах
- Аймгийн иргэд болон гадаад, дотоодын аялагчдыг мэдээллээр хангах
- АЖ-ын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах
- Жуулчны статистик тоо баримттай болох
- Байгаль хамгаалах талаар мэдлэг түгээх, сурталчлах
- Бие даан аялагчдад үйлчилгээ, бүтээгдэхүүнийг санал болгох, танилцуулах, мэдээлэл түгээх зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

Аймгийн аялал жуулчлалын веб хуудсыг Увс аймгийн болон Зам тээвэр аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын газар, Монголын аялал жуулчлалын холбоо, НИТАЖ-ын сүлжээ зэрэг Монголын аялал жуулчлалын салбарын гол веб сайтад холбох шаардлагатай юм.

Аймгийн аялал жуулчлалын имидж буюу “лого”-г бий болгох нь ихээхэн чухал. Имидж нь аймгийн аялал жуулчлалын өвөрмөц онцлогийг тодорхойлж бусдаас ялгарах бүтээгдэхүүн үйлчилгээний давуу талыг харуулна.

**Имиджийг бүрдүүлэхдээ:**

- Уламжлалт дүр төрхийг хадгалах
- Соёлын өвийг хадгалах
- Шинэ дүр төрхийг олж нээх гэсэн 3 хүчин зүйлийг нягт уялдуулах шаардлагатай.

**Увс аймгийн хувьд:**

- Дэлхийн өвд бүртгэгдсэн нутаг дэвсгэр
- Дэлхийн хамгийн хойд захын элс
- Дэлхийд ховордсон ирвэсийн өлгий нутаг
- Увс нуурын гайхам төрх байдал
- Түүх соёлын дурсгал

- Бий биелгээ, ардын ёс заншил
- Жамц давс
- Чацаргана г.м нэгэнт бүрдсэн давтагдашгүй онцлог, имидж, дээр тулгуурлан шинэ өнгө аясыг мэдрүүлсэн маркетингийн идэвхижүүлэлтийг бий болгох бололцоотой.

**Увс аймгийн хувьд дараах эвентийг зохион байгуулах боломжтой:**

- Ардын язгуур урлагын бэсрэг наадам-6-р сард
- Бий биелэгээний их наадам-5-р сар
- Овоо тахилгын бэсрэг наадам-6-р сард
- Уран бугуйлчдын улсын уралдаан-7-р сард
- Бух барилдаан-7-р сард
- Увс нуурын ханш нээх баяр-2-3 сард
- Чацаргана хураалтын баяр
- Цасны баяр-2-3 сард
- Эсгий хийх, мал хяргах -9-р сард
- Цагаан идээ боловсруулах-зуны улиралд

**ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх үр дүн
1	Жуулчдыг хүссэн мэдээллээр нь түргэн шуурхай хангах “Жуулчны мэдээллийн” төв байгуулах	2008-2009	Ажлын хэсэг, АЖ-ын байгууллагууд	Жуулчдын ая тухтай байдлыг хангаж чадахуйц орчин бүрдэнэ
2	АЖ-ын “Гийчин” төв, АЖ-ын төрийн бус байгууллагуудтай харилцаа холбоо тогтоож “Жуулчны мэдээллийн” төв байгуулахад хөрөнгө оруулах, хамтран ажиллах газрыг судлаж сонгох	2008	АЗДТГ, АЖ-ын зөвлөл	Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлж улмаар ажлын байрны тоог нэмэгдүүлэх
3	Аймгийн жуулчлалтай холбоотой арга хэмжээг тусгасан календарь хэвлүүлэх	Жил бүр	АЗДТГ, АЖ-ын зөвлөл	Аж-ын шинэ бүтээгдэхүүн бий болно
4	Улсын болон олон улсын үзэсгэлэн яармагт оролцож мэдээлэл сурталчилгаа явуулах	Жил бүр	АЗДТГ, УНАС-ын хамгаалалтын захиргаа, АЖ-ын байгууллагууд	Хамтран ажиллах, сурталчилгаанд орчин үеийн шинэ дэвшилтэт аргыг нэвтрүүлнэ
5	Жуулчдын олноор хүрэлцэн очдог газруудад мэдээллийн самбар, тэмдэг тэмдэглэгээг англи хэл дээр хийж тавих, маршрут чиглэлийн заасан самбарууд, газарчлах тэмдэглэгээтэй болох	Жил бүр	АЗДТГ, УНАС-ын хамгаалалтын захиргаа, АЖ-ын зөвлөл	Үйлчилгээний чанар сайжирна
6	Аймгийн веб хуудаст АЖ-ын холбоостой болох, Аймгийн АЖ, зочид буудлын үйлчилгээ, эрхэлдэг ААН-ийн танилцуулга, тэдгээрийн бүтээгдэхүүнээс интернетэд тавих	2008-2009	Ажлын хэсэг, АЖ-ын байгууллага	Үйлчилгээний хүрээ нэмэгдэх
7	Байгалийн үзэсгэлэнт, түүхийн дурсгалт газруудын талаар идэвхтэй сурталчилгаа явуулах/баримтат кино хийх, танилцуулга, товхимолууд гаргах, сонин сэтгүүл, радиогоор цуврал нэвтрүүлэг бэлтгэн явуулах/	2008	Ажлын хэсэг, хэвлэл мэдээллийн алба	Аяллын таатай орчин бий болгоход мэдээллийг өргөн ашиглах
8	Жуулчдын хоол хүнс, түргэн болон үндэсний хоолны сүлжээ байгуулах ААН-ийг дэмжих, чанарын стандарт мөрдүүлэх	2008-2010	АЗДТГ, МХГ	Жуулчдын аюулгүй тав тухтай байдлыг бий болгож үйлчилгээний чанар сайжирна
9	Зочид буудал, жуулчны баазын үйлчилгээний чанарын	2009	АЗДТГ, МХГ	Жуулчны байрлуулах

	зэрэглэл стандартыг тогтоох, атестатчилах			үйлчилгээний түвшин олон улсын жишигт хүрнэ
10	Ховор амьтдын өлгий нутгийн АЖ-ын бүсэд ажиллах жуулчны байршуулах хэрэгслийн эко стандартыг боловсруулах	2009	Ажлын хэсэг, Мэргэжлийн холбоод	үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ
11	Орон нутагт жуулчид аялахад тэдний аюулгүй байдлыг анхаарч ажиллах /жуулчны баазуудад эргүүлийн гэрээт цагдаа ажиллуулах зэрэг боломжуудыг судлах/	2008-2010	Ажлын хэсэг, холбогдох байгууллагууд	Жуулчдын аялах нөхцлын аюулгүй ажиллагаа бүрдэх
12	Аялал жуулчлалын бүсүүдэд түүний онцлогт тулгуурлан томоохон эвент арга хэмжээг зохион байгуулах, АЖ-ын брэнд бүтээгдэхүүнийг бий болгох	Жил бүр	Ажлын хэсэг, АЖЗ, АЖ-ын байгууллагууд	Шинэ бүтээгдэхүүнийг бий болгоно
12	аймгийн төвд олон ястны түүх соёл, зан заншил, эд зүйлсийн онцлогийг тусгасан аялал жуулчлалын иж бүрэн цогцолбор байгуулах төсөл боловсруулж, хөрөнгө оруулагч ивээн тэтгэгч, хамтран ажиллагчдыг олох	2008	Хөрөнгийн эх үүсвэр бий болох боломж бүрдэх	Ажлын хэсэг, Аялал жуулчлалын байгууллагууд
13	Аялал жуулчлалын нөөц бололцоонд тулгуурлан өөрсдийн өвөрмөц нэрийн бүтээгдэхүүнийг бий болгох /жуулчдыг зөвхөн байгалийн сайханд амруулах биш, тэдний сонирхол, идэвхи оролцоо шаардсан арга хэмжээнд оролцуулах, гэрийг нь өөрсдөөр бариулах г.м	2008-2010	Аялагчдын сонирхолд нийцсэн аяллын таатай орчин бүрдүүлэх	Ажлын хэсэг, Аялал жуулчлалын байгууллагууд
14	Аймгийн АЖ-ын зөвлөлийг санал болгож буй талуудын оролцоотойгоор байгуулах	2008	АЗДТГ, ажлын хэсэг	АЖЗ байгуулагдана
15	Аймгийн АЖЗ-ийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, АЖЗЗ-ийн ажиллах төлөвлөгөөг гаргах	2008	Ажлын хэсэг уулзалт хийж талуудыг ашиг сонирхолыг нарийн тодорхойлох	Эрх зүйн орчин бүрдэнэ
16	Рашаан сувилал, хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, сурталчлах, үйлчилгээний түвшинг нэмэгдүүлэх	2008-2012	Ажлын хэсэг, Аялал жуулчлалын байгууллагууд	Үйлчилгээний чанар сайжирна
17	Дотоодын жуулчдад зориулсан хямд үнэтэй, үйлчилгээ сайтай түр буудаллах цэгүүдийг барьж байгуулах ажлыг дэмжих	2008-2010	Ажлын хэсэг, Аялал жуулчлалын байгууллагууд	үйлчилгээний чанар сайжрана
18	УНАСУТХ-тай газруудын байгалийн даац, боломжийн судалгааг гаргаж, байгалийн аялал жуулчлалын тусгай	2008-2009	УНАС УТХГХЗ, Ажлын хэсэг	Тусгай хамгаалалттай газар аялах нөхцөл

	хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх			бүрдэх
19	Гадаад улс орнуудын аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хэлцэл байгуулж, хамтран ажиллах	2008-2012	Ажлын хэсэг, АЖЗ	Хамтран ажиллах нөхцөл бий болох
20	Амралт, рашаан сувилал, жуулчны баазуудыг тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах	2008-2010	Ажлын хэсэг	Үйлчилгээний чанар сайжирна
21	Засгийн газрын 1995 оны 169 дүгээр, тогтоолын 3 дугаар хавсралт. Дархан цаазат болон байгалийн цогцолборт зарим газрын тусгай горимыг мөрдлөгө болгох	2008	УНАСУТХГ, Ажлын хэсэг	Тусгай хамгаалалттай газар аялах нөхцөл бүрдэх
22	АЖ эрхэлдэг ААН, компани, зочид буудал үйлчилгээний газрын бүртгэлийг шинэчлэх	2008	Ажлын хэсэг	
23	Баруун бүсийн аялал жуулчлалын нэгдсэн маршрут, жуулчин солилцох сүлжээ байгуулах	2008	Ажлын хэсэг, Аялал жуулчлалын байгууллагууд	Баруун бүсийн сүлжээ бий болох
24	Аймгийн АЖ-ын зургыг өнгөтөөр хэвлүүлэх, түгээх	2008	Ажлын хэсэг	Аймагт АЖ-ын зураг бий болно
25	Аймгийн төв болон хот орчмын тойрон аяллын маршрутыг батлан гаргаж сурталчлах, танин мэдэхүйн аяллыг хөгжүүлэх	2008-2010	Ажлын хэсэг, Хотын захирагчийн ажлын алба	Тойрон аяллыг хөгжүүлэх
26	Бүсийн аялал жуулчлалын нэгдсэн маршрут, жуулчин солилцох сүлжээ байгуулах, гадаад, дотоодын аялагч, амрагчдын тоог нэмэгдүүлэх, сурталчлах	2008-2012	Ажлын хэсэг, Аялал жуулчлалын байгууллагууд	Баруун бүсийн жуулчны сүлжээг бий болгох
27	Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх	2008-2016	АЗДТГ, Ажлын хэсэг	
28	Аймгийн төвд тохилог зочид буудал, зоогийн газар, үйлчилгээний төв, бэлэг дурсгалын дэлгүүрүүдийн тохижилтыг сайжруулж үйлчилгээнд түлхүү анхаарах	2008-2016	Ажлын хэсэг,	үйлчилгээний чанар сайжрах
29	Хүүхэд залуучууд, аж ахуйн нэгжүүдийн дунд тойрон аяллын экскурсыг зохион байгуулах	2008-2014	Ажлын хэсэг	
30	Тусгай хамгаалалттай газар нутгуудад аялал жуулчлал хөгжүүлэх менежментийг хариуцсан орон тооны бус зөвлөлийг байгуулж ажиллуулах	2008-2009	Ажлын хэсэг, УНАСУТХГХЗахиргаа	
31	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2008-2012	Ажлын хэсэг	Олон нийтийн оролцоог идэвхижүүлэх
32	Төвийн бүсийн дотоодын аялал жуулчлалын туршлагыг	2008-2010	Ажлын хэсэг	

	судалж, хэрэгжүүлэх			
33	Хяргас, Айраг, Үүрэг, Ачит нуурууд болон голуудын ай сав газруудыг түшиглэн усны аялал хөгжүүлэх, загас, шувуу барих, агнах нөхцөлийг хангах	2008-2016	Аялал жуулчлалын байгууллагууд, АЖЗ	үйлчилгээний чанар сайжрах
34	Увс, Хяргас нуурт усанд орох наран шарлагын газруудыг өргөжүүлэн тохижуулж жуулчид хүлээн авч үйлчлэх тохилог орчин бий болгож орчны тохижилтыг сайжруулах.	2008-2014	Аялал жуулчлалын байгууллагууд, АЖЗ	үйлчилгээний чанар сайжрах
35	Ангийн зохих нөөц бүхий газруудад суурин ба нүүдлийн отог зохион байгуулж гадаадын анчин жуулчдыг хүлээн авч үйлчлэх	2009-2014	Аялал жуулчлалын байгууллагууд, АЖЗ	үйлчилгээний чанар сайжрах
36	АЖ, зочид буудлын үйлчилгээ, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх мэргэжлийн боловсон хүчинг Улаангом коллежийг түшиглэн явуулах	2008-2010	АЖЗ, АЖ-ын байгууллагууд	АЖ-ын үйлчилгээнд чадвартай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэнэ
37	Орон нутгийн аяллын хөтөч, газарчинд зориулсан сургалт	2008-2012	АЖЗ, АЖ-ын байгууллага	
38	НИТАЖ-ын сургалт зохион байгуулах /тогтвортой хөгжлийг хангах зорилгоор шийдвэр гаргагчид ба НИТАЖ/	2008-2012	АЖЗ, АЖ-ын байгууллагууд	
39	Зочид буудал, зоогын газар үйлчилгээний байгууллагад ажиллагсдын сургалт	2009	АЖЗ, АЗДТГ	
40	Орон нутгийн АЖ-ын бизнес, үйлчилгээ эрхлэгчдэд сургалтыг үе шаттай явуулах	2008-2010	АЖЗ, АЖ-ын байгууллагууд	



График 1. Увс аймгийн агаарын температурын жилийн дундаж ( $^{\circ}\text{C}$ ) хэм






График 2. Увс аймгийн хур тунадастай өдрийн тоо



**График 3. Баруун бүсийн засаг захиргааны нэгж /нутаг дэсвэгийн хэмжээ, мян.км<sup>2</sup>/**



**График 4. Баруун бүсийн засаг захиргааны нэгж /хүн амын нягтаршлаар, 2006 он/ 1 кв.км-т ногдох хүн**




График 5. Баруун бүсийн аймгуудын суурин хүн амын тоо (мян.хүн)






График 6. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо



**График 7. Увс аймгийн малын тоо, мян.толгой  
/2003-2006 он/**



**График 8. Увс аймгийн таван хошуу малын тоо,  
(мян.толгой) 2006 он**




График 9. Баруун бүсийн аймгуудын малын тоо, мян.толгой /2006 он/







График 10. Боршоо боомтоор хил нэвтэрсэн гадаад дотоодын зорчигчдын тоо



**Бургастай боомтоор хил нэвтэрсэн гадаад дотоодын зорчигчдын тоо**




**График 11. Боршоо боомтоор нэвтэрсэн дотоод зорчигчдын тоо /аялалын зорилгоор, 2006 он/**




■ Албан ажлаар ■ Хувийн шугамаар ■ Байнга оршин суух

**Бургастай боомтоор нэвтэрсэн дотоод зорчигчдын тоо /аялалын зорилгоор, 2006 он/**



■ Албан ажлаар ■ Хувийн журмаар ■ Байнга оршин суух

**График 12. Боршоо боомтоор нэвтэрсэн дотоод зорчигчдын тоо /аялалын зорилгоор, 2006 он/**



**Бургастай боомтоор нэвтэрсэн дотоод зорчигчдын тоо /аялалын зорилгоор, 2006 он/**






График 13. Увс аймгийн музейн үзвэр, үзэгчид /үзмэрийн тоо, үзэгчдээр/





График 14. Баруун бүсийн аймгуудын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт /сая, төг/



**График 15. Увс аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн /2006 он/  
(49.8 тэрбум төгрөг, үүнд эзлэх хувь салбараар)**

